

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭ СУУРЬШЛЫН БҮСЭД УЛСЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ"-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

ШИНЭ СУУРЬШЛЫН БҮСИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭХ ҮҮСВЭР ДУТМАГААС БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛУУД ДУУСААГҮЙ, ИРГЭДИЙГ СУУРЬШУУЛАХ АЖИЛ ХАНГАЛТГҮЙ БАЙГАА НЬ 2018-2024 ОНД ТӨЛӨВЛӨСӨН ЗОРИЛТОТ ТҮВШИНД ХҮРЭХГҮЙ БАЙХ ЭРСДЭЛИЙГ ДАГУУЛЖ БАЙНА.

АУДИТЫН КОД: БНА-2023/33-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу
Цахим хуудас: www.open.audit.mn

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын **дарга,**
тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер А.Цэням
Утас: 70442424 цахим хуудас: tseenyma@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Азбаяр
Утас: 99061429 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Должмаа
Утас: 88110538 цахим хуудас: doljmaab@audit.gov.mn
Аудитор Б.Нарангэрэл
Утас: 99009293 цахим хуудас: narangerelb@audit.gov.mn
Аудитор Н.Батчимэг
Утас: 91113253 цахим хуудас: batchimegn@audit.gov.mn

Баянхонгор хот 2023

Тайланг хянасан

Баянхонгор аймаг дахь
Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор
Б.Мөнхбат

Тайланг бэлтгэсэн:

Аудитын менежер
А.Цээням
Ахлах аудитор Б.Азбаяр
Ахлах аудитор Б.Должмаа
Аудитор Б.Нарангэрэл
Аудитор Н.Батчимэг

2023 оны 10 дугаар сарын
11-ний өдөр

Уг тайланг УАГ-ын
цахим хуудаснаас үзнэ үү:
www.open.audit.mn

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70442424
дугаарын утас, 70442584
дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ:

Баянхонгор аймаг дахь
Төрийн аудитын газар,
Нутгийн удирдлагын
ордон,
Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум 64090,
Баянхонгор аймаг
Монгол Улс

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх
мэдэгдэл 3

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ 4

БҮЛЭГ 1. ШИНЭ СУУРЬШЛЫН БҮСИЙН ТӨЛӨВЛӨЛТ НЬ
БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ УЯЛДСАН, ХҮН АМЫН ӨСӨН
НЭМЭГДЭЖ БАЙГАА НИЙГМИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ
ХАНГАСАН БАЙНА 6

1.1. Баянхонгор сумын "Шинэ суурьшлын бүс"-ийн хөрөнгө
оруулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа урт, дунд хугацааны
бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн байна. 6

1.2. Шинэ суурьшлын бүсийг байгуулах хэсэгчилсэн ерөнхий
төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалтын ажлуудыг үе шаттай
хийгдэж байгаа ч хөрөнгийн үр ашгийг хүртэхэд санхүүжилтийн эх
үүсвэрийг иж бүрэн шийдвэрлэх шаардлагатай байна. 7

БҮЛЭГ 2. ШИНЭ СУУРЬШЛЫН БҮСИЙН БҮТЭЭН
БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСВИЙГ ТӨСӨВ
БАТЛАГДСАНААС ХОЙШ МАГАДЛАЛ ХИЙЛГЭСНЭЭС
ШАЛТГААЛАН ТЕНДЕР ЗАРЛАСАН АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭГЭЭР
АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ БОЛОМЖҮЙ ҮР ДАГАВАР ҮҮСЭЖ БАЙНА.

12

2.1. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд
магадлал хийхдээ Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалтыг
зөрчсөн байна. 12

2.2. Тендерийн үнэлгээний хороо төсөл, арга хэмжээний
гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа хууль, журмыг баримталж
ажиллаагүй байна. 14

2.3. Зарим төсөл арга хэмжээг гүйцэтгэхдээ тендерт зарласан
анхны зураг төсвийг өөрчлөн гүйцэтгэсэн байна. 17

2.4. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг
сайжруулах шаардлагатай байна. 27

2.5. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. 28

БҮЛЭГ 3. ШИНЭ СУУРЬШЛЫН БҮСИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ НЬ ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД БОДИТОЙ
ХУВЬ НЭМЭР ОРУУЛСАН БАЙНА. 29

3.1. Хөрөнгө оруулалтаар бий болсон эмнэлгийн барилгаас бусад
хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байна. 29

3.2. Шинэ суурьшлын бүсэд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр
бий болсон хөрөнгө, дэд бүтэц, бүтээн байгуулалт нь орон
нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр үзүүлж байна. 31

ДҮГНЭЛТ: 36

ЗӨВЛӨМЖ: 37

Товчилсон үгийн тайлбар

АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ТББ	Төрийн бус байгууллага
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ЦТХХК	Цахилгаан түгээх хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
КТП	КТП-комплектная трансформаторная подстанция (иж бүрэн дэд станц)

Хүснэгтийн тайлбар

Хүснэгт № 1	Шинэ суурьшлын бүсэд хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ
Хүснэгт № 2	Шинэ суурьшлын бүсийн инженерийн хангамжийн шугам сүлжээний ажлын нэгдсэн товчоо
Хүснэгт № 3	Баянхонгор аймгийн шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан шаардлагатай барилга байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэл
Хүснэгт № 4	Зураг төсөл болон магадлалын дүгнэлтийн мэдээлэл
Хүснэгт № 5	Ингэний сүүний үйлдвэрийн гэрээнд тусгасан ажлууд
Хүснэгт № 6	Шинэ суурьшлын бүсийн хөрөнгө оруулалтын санхүүжилт
Хүснэгт № 7	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
Хүснэгт № 8	Шинэ суурьшлын бүсийн зерэг ба сөрөг үр дүн
Хүснэгт № 9	Ингэний сүүний үйлдвэрийн ашгийн тооцоолол

Хавсралтын тайлбар

Хавсралт № 1	Бодлогын баримт бичгийн уялдаа холбоо
Хавсралт № 2	Богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан хөрөнгө оруулалтын төлөвлөлт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит
хийсэн
үндэслэл,
бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний дагуу аудитыг гүйцэтгэв.

Аудитын
зорилт

Баянхонгор аймгийн Шинэ суурьшлын бүсэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа арга хэмжээ, бүтээн байгуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Шинэ суурьшлын бүсийн ерөнхий болон нарийвчилсан төлөвлөлтийн ажлыг холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичигт үндэслэн үр ашигтай төлөвлөсөн эсэх
- Шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөлтийн дагуу ил тод, үр дүнтэй хэрэгжүүлж буй эсэх.
- Бүтээн байгуулалтаар бий болсон хөрөнгө оруулалт нь орон нутгийн хөгжилд бодит үр дүн өгч буй эсэх.

Аудитын
хамарсан
хүрээ

Шинэ суурьшлын бүсэд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө болон хандив тусламжийн эх үүсвэрээр бүтээн байгуулсан хөрөнгө оруулалт болон төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, үр дүнг аймгийн ИТХ, ЗДТГ, Засаг даргын холбогдох үйл ажиллагааг хамруулан шалгав.

Аудитын
хязгаарлалт
Аудитын арга
зүй, шалгуур
зүүллэлт

Аудитад шинэ суурьшлын бүсийн газар олголтыг хамааруулаагүй болно.

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер А.Цээням хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Азбаяр ахалж, ахлах аудитор Б.Должмаа аудитор Б.Нарангэрэл, Н.Батчимэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөөг 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн дотор батлуулж, талбарын ажлыг 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрөөс 09 дүгээр сарын 11-ний өдрийн хугацаанд гүйцэтгэж аудитын тайланг удирдлагын зөвлөлийн хурлаар 09 дүгээр сарын 20-ны өдөр хэлэлцүүлж, дарга, тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

Хүндрэл
бэрхшээл

Байхгүй

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны 2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 115 дугаар тогтоолоор Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх, суурьшлын бүсийг тэлэх иргэдийн амьдрах таатай орчныг бүрдүүлэх зорилгоор Баянхонгор хотын Есөнбулаг 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт Шинэ суурьшлын бүсийг байгуулах тухай шийдвэр гаргаж, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, зураг төслийг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгэх, төлөвлөгөөний дагуу суурьшлын бүсийг байгуулж, инженерийн болон нийгмийн дэд бүтцийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэж хэрэгжилтийг хангаж ажлыг зохион байгуулж эхэлжээ.

Аймгийн ЗДТГ-ын захиалгаар “Хот байгуулалтын хөгжлийг дэмжих төв” ХХК-тай гэрээ байгуулан Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хуралдааны 2019.04.19-ний өдрийн 16/01 тоот тогтоолоор Шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөөг баталсан байна.

Баянхонгор сумын шинэ суурьшлын бүсэд 2019-2023 онд нийт 35,241.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 төсөл, арга хэмжээг төлөвлөж, 35,187.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн байна.

Шинэ суурьшлын бүсэд хэрэгжүүлэх 1,303.8 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тендерийн үнэлгээний хороо ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчсөн байна.

Дээрх хөрөнгө оруулалтын ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 20,761.7 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 601.2 сая төгрөг, хандив тусламжаар 260.6 сая төгрөгөөр гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 1. Шинэ суурьшлын бүсэд хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ (сая.төг)

№	Эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Санхүүжүүлсэн дүн
1	Улсын төсөв	Сургуулийн барилга, 640 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/	Барилга байгууламж	5,166.1	5,166.1	5,144.8
2	Улсын төсөв	Эрүүл мэндийн төвийн барилга, 14 ор /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/	Барилга байгууламж	1,013.3	1,011.4	1,011.4
3	Улсын төсөв	"Цэвэр хот" төсөл хэрэгжүүлэх /Баянхонгор, Баянхонгор сум/- Шинэ суурьшлын бүсийн гадна цэвэр усан хангамж, бохир усны шугамын ажлын материал нийлүүлэх	Тоног төхөөрөмж	1,000.0	995.0	989.0
	Хандив	Шинэ суурьшлын бүсийн шугам угсралтын ажил	Ажлын хөлс	40.0	40.0	40.0
	Хандив	Шинэ суурьшлын бүсийн 2 ширхэг ундны усан сангийн ус тусгаарлалтын ажил	Ажлын хөлс	15.6	15.6	15.6
	Хандив	Шинэ суурьшлын бүсийн газар шорооны ажил	Ажлын хөлс	104.4	104.4	104.4
4	Улсын төсөв	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/- ингэний сүүний үйлдвэрийн барилгын ажил	Барилга байгууламж	3,848.1	3,848.1	1,287.7
5	Улсын төсөв	Хөдөө аж ахуйн кластер багц 2: Ногоон тэжээлийн үйлдвэр	Барилга байгууламж	2,584.6	2,584.6	559.5
6	Улсын төсөв	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/ мах, хүнсний ногооны 1000 тонн агуулахын барилга	Барилга байгууламж	3,094.4	3,094.4	2,044.8
7	Улсын төсөв	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/ Шинэ суурьшлын бүсийн гадна холбооны шугам материал нийлүүлэх захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээ	Тоног төхөөрөмж	811.4	808.1	686.8

	Хандив	Шинэ суурьшлын бүсийн гадна холбооны ажил	Ажлын хөлс	10.6	10.6	10.6
8	Улсын төсөв	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/ цэвэрлэх байгууламж- Шинэ суурьшлын бүсэд цэвэрлэх байгууламж ТОПАЭРО төхөөрөмж	Тоног төхөөрөмж	451.0	450.0	450.0
9	Улсын төсөв	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/ Цахилгааны эх үүсвэрийн ажил гүйцэтгэх, материал нийлүүлэх	Тоног төхөөрөмж	1,210.5	1,210.5	1,195.0
	Хандив	Шинэ суурьшлын бүсийн цахилгааны угсралтын ажил	Ажлын хөлс	30.0	30.0	30.0
10	Улсын төсөв	Баянхонгор аймгийн цөлжилт, газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах	Ногоон байгууламж	100.0	99.9	99.9
	Орон нутгийн төсөв	Баянхонгор аймгийн цөлжилт, газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах	Ногоон байгууламж	71.0	64.1	64.1
	Орон нутгийн төсөв	Баянхонгор аймгийн цөлжилт, газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах	Худаг гаргах	20.0	20.0	20.0
	ОНХС	Баянхонгор аймгийн цөлжилт, газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах	Худаг гаргах	20.0	20.0	20.0
	ОНХС	Баянхонгор аймгийн цөлжилт, газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах	Ногоон байгууламж	127.8	98.7	98.7
11	Улсын төсөв	Аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээ /Баянхонгор, Баянхонгор сум/	Барилга байгууламж	7,032.9	7,032.9	3,482.1
12	Улсын төсөв	Аймгийн шинэ суурьшлын бүсийн хатуу хучилттай авто зам, 10 км /Баянхонгор, Баянхонгор сум	Барилга байгууламж	8,000.0	7,995.2	3,810.8
13	ОНХС	Шинэ суурьшлын бүсийг эрчим хүчинд холбох /Баянхонгор аймаг, Баянхонгор сум/	Тоног төхөөрөмж	300.0	300.0	276.0
14	БОХНСАХ-ны зардал	Шинэ суурьшлын бүсэд мод үржүүлгийн газар байгуулах	Ажил	130.0	127.7	122.4
	Хандив	Шинэ суурьшлын бүсэд мод үржүүлгийн газар байгуулах	Багаж тоног төхөөрөмж	15.1	15.1	15.1
	Хандив	Шинэ суурьшлын бүсэд мод үржүүлгийн газар байгуулах	Тарьц, суулгац	44.9	44.9	44.9
ДҮН				35,241.7	35,187.3	21,623.5

Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээ шийдвэрлэгдээгүйгээс 2019 онд барьсан эмнэлэг, сургуулийн барилгын техникийн нөхцөлийг мэргэжлийн байгууллагууд олгоогүй, Ингэний сүүний үйлдвэр байгуулах, Мод үржүүлгийн газар байгуулах зэрэг арга хэмжээг гүйцэтгэхдээ тендерт зарласан анхны зураг төсвийг өөрчлөн гүйцэтгэсэн байна.

Санхүүжилт олгосон дээрх төсөл арга хэмжээнээс 640 хүүхдийн сургууль, 14 ортой эмнэлэг барих, Шинэ суурьшлын бүсийг эрчим хүчинд холбох, Баянхонгор аймгийн цөлжилт, газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах, шинэ суурьшлын бүсийн гадна цэвэр усан хангамж, бохир усны шугамын ажлын материал нийлүүлэх зэрэг төсөл арга хэмжээнүүдийг бүрэн хийж, 2019-2022 онуудад ашиглалтад авсан байна.

Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах арга хэмжээний хүрээнд 2021-2022 хийхээр баталсан 6 багц төсөл арга хэмжээнээс цахилгааны эх үүсвэрийн ажлын материал нийлүүлэх ажлаас бусад ажил хийгдэж дуусаагүй байна.

Шинэ суурьшлын бүсэд баригдаж 2021 оны 11 дүгээр сард улсын комисс хүлээн авсан 5,166.1 сая төгрөгийн 640 хүүхдийн сургууль, 300.0 сая төгрөгийн санхүүжилтээр бий болсон 10/0.4кВ-ын ЦДАШ-ийн ажил, 35 кВ-ийн ЦДАШ, дэд

станцын байгууламжийг эрх бүхий байгууллагууд шийдвэр гаргаагүйгээс нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

БҮЛЭГ 1. ШИНЭ СУУРЬШЛЫН БҮСИЙН ТӨЛӨВЛӨСӨН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР ДУТМАГ БАЙГААГААС АЖИЛ УДААШРАЛТАЙ, ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТОД ТҮВШИН ХАНГАГДАХГҮЙ, ОРХИГДОХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА.

1.1. Баянхонгор сумын “Шинэ суурьшлын бүс”-ийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа урт, дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан 2,300 өрхийн 8,000 орчим хүн амыг суурьшуулахаар төлөвлөжээ.

1.1.1. “Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ийн 9.1¹ дэх заалттай уялдуулан дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээний хүрээнд Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүсэд 35,187.3 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

АЛСЫН ХАРАА-2050



БҮС НУТГИЙН ХӨГЖИЛ

Зорилго 8. “Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлнэ”

Зорилт 8.1. “Бүс нутгийн эдийн засгийн интеграцад дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр бүрэн холбогдож, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлнэ”

- “Цэвэр хот” төсөл хэрэгжүүлэх
- Гадна холбооны шугам
- Цэвэрлэх байгууламж
- Цахилгааны эх үүсвэр
- Инженерийн шугам сүлжээ
- Хатуу хучилттай авто зам



ХҮН ТӨВТЭЙ ХОТ

Зорилго 9. “Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ”

Зорилт 9.1. “Иргэдийнхээ хөгжих боломжийг хангасан хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй эрүүл чийрэг, бүтээгч, оюунлаг иргэдтэй хот болно”



14 ортой эмнэлэг

Зорилт 9.2. “Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно”

Зорилт 9.3. “Орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж байгаа дагуул хотуудтай олон улсад Өрсөлдөгч метрополитан болж хөгжинэ”



640 хүүхдийн сургууль

Зорилт 8.3-т “Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ”

- Ингэний сүүний үйлдвэр
- Ногоон тэжээлийн үйлдвэр
- Мах, ногооны 1000 тн зоорь
- Цөлжилт, газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах



Шинэ суурьшлын бүсэд хийгдэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнүүд нь НҮБ-аас 2015 онд баталсан “Тогтвортой хөгжлийн зорилго”-ын “Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих” зорилгын 11.а²-д заасныг хангахад чиглэсэн байна.

¹ Иргэдийнхээ хөгжих боломжийг хангасан хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй эрүүл чийрэг бүтээгч, оюунлаг иргэдтэй хот болно.

² Үндэсний болон бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтийг сайжруулах замаар хот, хагас суурин газар, хөдөө орон нутгийн хооронд эдийн засаг, нийгэм, байгаль орчны үр дүнтэй уялдаа холбоо дэмжих

1.1.2 Шинэ суурьшлын бүсэд хийгдэж буй хөрөнгө оруулалтыг “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”, “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт нийцүүлэн төлөвлөсөн байна.

“Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”-ын зорилт 3 “Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, аялал жуулчлалыг хослуулсан кластер”, зорилт 4 “Дэд бүтэц-хөгжлийн тэгш боломж” гэсэн зорилтын хүрээнд дэвшүүлсэн арга хэмжээнүүдэд уялдуулсан байна.

Баянхонгор аймгийн хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн дараах зорилтуудтай нийцсэн байна. Үүнд:

- Шинэ суурьшлын бүсийн 640 хүүхдийн сургуулийн барилга, 14 ортой эрүүл мэндийн төвийн барилга барих ажлууд-Зорилтын 2.5, 6.1.9;
- Баянхонгор аймгийн цөлжилт, газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах ажил нь 2.5.4;
- “Цэвэр хот” төсөл хэрэгжүүлэх ажил нь 2.5.5, 6.1;
- Цахилгааны эх үүсвэрийн ажил гүйцэтгэх, материал нийлүүлэх ажил нь 4.2.4;
- Хатуу хучилттай 10 км авто зам хийх ажлууд нь 4.2.5;
- Ингэний сүү боловсруулах үйлдвэр байгуулах ажил нь 4.2.6, 4.2.7;
- Гадна холбооны шугам материал нийлүүлэх ажил нь 5.2.1, 8.1;
- Цэвэрлэх байгууламж байгуулах ажил нь 8.1.5, инженерийн шугам сүлжээний ажил нь 8.1.8;
- Ногоон тэжээлийн үйлдвэр, мах, ногооны 1000 тонны агуулахын барилга нь 8.1.13 дахь нийцсэн байна.

Дээрх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлууд нь Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020, 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох заалтуудтай нийцсэн байна. (Хавсралт 1)

1.1.3. Шинэ суурьшлын бүсийг байгуулах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг жил бүрийн Аймаг хөгжүүлэх хөгжлийн төлөвлөгөөнд, шаардлагатай хөрөнгө оруулалтыг тусгаж ирсэн байна.

Шинэ суурьшлын бүсийг байгуулах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг жил бүрийн Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Аймаг хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөөнд жил бүр тусгаж 2018-2023 онд 54,535.7 сая төгрөгийн 17 төсөл арга хэмжээг баталсан байна.

Үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 34,312.3 сая, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 712.4 сая, бусад эх үүсвэрээр 19,511.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэхээ төлөвлөжээ. (Хавсралт 2)

1.2. Шинэ суурьшлын бүсийг байгуулах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалтын ажлуудыг үе шаттай хийгдэж байгаа ч хөрөнгийн үр ашгийг хүртэхэд санхүүжилтийн эх үүсвэрийг иж бүрэн шийдвэрлээгүй байна.

1.2.1. Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдаанаар Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүс байгуулахаар шийдвэрлэсний дагуу 383 га газарт байр зүйн зураг, инженер геологийн судалгаа хийлгэж, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 2019 онд эцэслэн баталсан байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 14/8 дугаар тогтоолоор 2012 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар “Шинэ суурьшлын бүс нутгийн 2300 га газарт байр зүйн зураг, инженер геологийн судалгаа, ерөнхий төлөвлөгөө хийлгэх” арга хэмжээнд 150.0 сая төгрөгийг баталж, гүйцэтгэгчээр

“ХБХДТ” ХХК-ийг шалгаруулж, 149.4 сая төгрөгөөр гүйцэтгэхээр аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсан байна.

Гэрээнд Баянхонгор сумын шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, экспертизээр батлуулан хүлээлгэн өгөх ажлыг 2012 оны 07 дугаар сарын 20-ны өдрөөс 2013 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл хугацаанд хийхээр тохиролцож, 2012-2013 онд 103.8 сая төгрөгийг гүйцэтгэгч аж ахуйн нэгжид олгосон байна.

Гүйцэтгэгч аж ахуйн нэгж ажлын тайлангаа 2012 оны 12 дугаар сарын 18-ны өдөр аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулсан боловч аймгийн ИТХ-аас холбогдох санал өгөөгүйгээс тухайн ажлыг эцэслэн баталгаажуулаагүй байна.

Дээрх ажлыг үргэлжлүүлэн Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 25 дугаар тогтоолоор ажлын хэсэг байгуулж “Аймгийн төвийн багуудын хилийн цэсийг өөрчлөх, шинэ суурьшлын бүсийг төлөвлөх, нэршлийг шинэчлэн тодотгох ажлыг судалж, байршил болон инженерийн дэд бүтэц, эдийн засгийн тооцоог гаргаж, аймгийн ИТХ-ын 2017 оны 115 дугаар тогтоолоор Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх, суурьшлын бүсийг тэлэх, иргэдийн амьдрах таатай орчныг бүрдүүлэх зорилгоор Баянхонгор хотын Есөнбулаг 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт Шинэ суурьшлын бүсийг байгуулахаар болжээ.

Уг тогтоолоор “Шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, зураг төслийг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгэх хөрөнгийг 2017 оны төсвийн тодотголоор шийдвэрлүүлэн, төлөвлөгөөний дагуу шинэ суурьшлын бүсийг байгуулж, инженерийн болон нийгмийн дэд бүтцийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргад үүрэг болгосны дагуу аймгийн Засаг дарга шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөөг гүйцэтгэж байсан “ХБХДТ” ХХК-тай 2012 онд байгуулсан гэрээнд нэмэлт оруулж үлдэгдэл санхүүжилт болох 41.4 сая төгрөгийг олгож ажлыг гүйцэтгүүлсэн байна.

1.2.2. Баянхонгор сумын шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөөг хот төлөвлөлт барилга зураг төслийн “ХБХДТ” ХХК хийж гүйцэтгэсэн байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 25 дугаар тогтоолыг үндэслэн Баянхонгор аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга нар “Шинэ суурьшлын бүс байгуулах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгавар”-ыг боловсруулж, 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдөр байгуулж, зураг төслийн эхний ээлжийг 2018-2024 он, 2 дугаар ээлжийг 2024-2028 онд хийхээр төлөвлөсөн байна.

Шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах талаар захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан БХ-2018/ТЗ-03 дугаар нэмэлт гэрээг 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдөр аймгийн Засаг дарга, “ХБХДТ” ХХК-ийн захиралтай байгуулж, Баянхонгор сумын шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, улсын экспертизээр болон орон нутгийн холбогдох мэргэжлийн байгууллагуудаар хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх ажлыг аймгийн ОНХС-ийн 41.4 сая төгрөгөөр 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдрөөс тус оны 05 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд хийхээр тусгажээ.

Баянхонгор сумын шинэ суурьшлын бүс байгуулах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Барилгын хөгжлийн төвийн 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 47/2019 дүгээр магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулж эцсийн тайланг хүлээлгэн өгсөн байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 16/01 дүгээр тогтоолоор аймгийн ЗДТГ-ын захиалгаар “Хот байгуулалтын хөгжлийг дэмжих төв”-ийн гүйцэтгэсэн “Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөө”-г Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын ж³, Хот байгуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 18.1.1⁴ дэх заалтыг үндэслэн баталжээ.

1.2.3.Төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хэсэгчилсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу төлөвлөж, хөрөнгө оруулалтыг бүрэн шийдвэрлэж чадаагүй байна.

Баянхонгор сумын шинэ суурьшлын бүсэд 2018-2028 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр 960 хүүхдийн сургууль, 40 хүүхдийн хүчин чадалтай дотуур байр, 730 хүүхдийн цэцэрлэг, 70 хүүхдийн ясли, 35 хүний хүчин чадал бүхий өрхийн эмнэлэг, амбулатори, 10 ортой эмнэлэг, 1 эмийн сан, 200 суудалтай кино театр, 300 суудалтай соёлын төв, 80 суралцагчтай хүүхдийн ордон, 120 уншигчтай номын сантай байхаар тооцоолсон байна. Үүнээс гадна 8 нэр төрлийн худалдаа, нийтийн хоолны байгууламж, 7 төрлийн нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууламж, засаг захиргааны байгууллага, цагдаагийн газар, банкны 2 салбар, оффис, инженерийн шугам сүлжээний дэд бүтцийн ажил зэргийг төлөвлөсөн байна.

Дээрх хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхээр шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслийг боловсруулах арга хэмжээнд 2020 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 200.0 сая төгрөгийг шийдвэрлэж, тендерт шалгарсан зураг төслийн “ДНТ” ХХК-ны гүйцэтгэсэн төсвийг зураг төслийн “Инж байгууламж” ХХК баталгаажуулан, шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлын төсвийг дараах байдлаар тооцсон байна.

Хүснэгт 2. Шинэ суурьшлын бүсийн инженерийн хангамжийн шугам сүлжээний ажлын нэгдсэн товчоо (сая.төг)

№	Ажил ба зардлын нэр	Төсөвт өртөг		
		Барилгын ажил	Тоног төхөөрөмжийн өртөг	Бүх төсөвт өртөг
1	Дулаан хангамж	17,470.9	2,099.2	19,570.1
2	Ус хангамж, ариутгах татуурга	5,740.1	-	5,740.1
3	Гадна холбоо	1,522.7	-	1,522.7
4	Зураг төслийн үнэ	200.0		200.0
	ДҮН	24,933.7	2,099.2	27,032.9


Эх сурвалж: Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлын төсөв

Инженерийн хангамжийн шугам сүлжээний тооцоолсон 27,032.9 сая төгрөгийн өртөг бүхий ажлаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд 7,032.9 сая төгрөгийн инженерийн шугам сүлжээний ажлын төсөв батлагдсан байгаа нь дулаан хангамж, цэвэр бохир усны зарим хэсгийн төв магистраль шугам байгуулах ажлуудыг төсвийг шийдвэрлэсэн байна.

Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Хөдөө аж ахуйн кластер” төслийн хүрээнд Баянхонгор аймгаас шинэ суурьшлын бүсийг холбох гадна холбооны шугам, цахилгааны шугам, цэвэрлэх байгууламжийг шийдвэрлэхэд 2,471.9 сая, “Цэвэр хот” төслийн хүрээнд цэвэр усны шугамыг холбоход 1,000.0 сая төгрөг баталсан байна.

Шинэ суурьшлын бүсийн хэмжээнд 960 хүүхдийн сургууль барихаар төлөвлөснөөс 640 хүүхдийн сургуулийг 5,166.1 сая, 14 ортой эмнэлгийг 1,013.3 сая, үйлдвэрлэлийн бүсэд "Хөдөө аж ахуйн кластер" төслөөр Ингэний сүү боловсруулах үйлдвэрийг 3,848.1 сая, Мах ногооны 1000 тонны багтаамжтай зоорийг 3,094.4 сая, Ногоон тэжээлийн үйлдвэрийг 2,584.6 сая, 10 км хатуу хучилттай автозамыг 8,000.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр 2019-2023 онуудад төсөв батлагдаж хэрэгжиж байна.

Харин шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийн ажлуудыг төлөвлөсөн хэмжээнд хөрөнгө бүрэн батлагдаагүйгээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хөдөө, аж ахуйн кластер төслөөр 1,195.5 сая, аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 300.0 сая, хандиваар 57.0 сая төгрөгийн ажлыг (зурагт ногооноор тэмдэглэсэн хэсгийг) хийж гүйцэтгэсэн байна.



Шинэ суурьшлын бүсэд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймгийн цөлжилт, газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах ажилд нийт 468.8 сая төгрөгийн төсөв батлагдаж хэрэгжсэн байна.

Аудитаар "Шинэ суурьшлын бүс"-д байгуулах барилга байгууламжийг төлөвлөгөөнд тусгагдсантай харьцуулахад ажлын явц хангалтгүй, удаашралтай, хөрөнгө оруулалтын эх үүсвэр дутмаг байгаагаас цаашид төлөвлөсөн зорилтод түвшинд хугацаандаа хүрэхгүй орхигдох эрсдэлтэй байна.

Хүснэгт 3. Баянхонгор аймгийн шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан шаардлагатай барилга байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэл /2023.09.30-ны байдлаар/

№	Үзүүлэлт	Байгууламжийн тоо	
		Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Боловсролын байгууламж	4	1
2	Эрүүл мэндийн байгууламж	3	1
3	Соёл, урлагийн байгууламж	4	-
4	Худалдаа, нийтийн хоолны байгууламж	8	-
5	Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууламж	7	-
6	Удирдлага, санхүү, зураг төсөл, олон нийтийн байгууламж	4	-
ДҮН		30	2

Эх сурвалж: Шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөө

Иймд орон нутгийн хөрөнгө оруулалтыг олон арга жижиг хэмжээнд бус оновчтой томоохон төсөл арга хэмжээнд ахиу байдлаар хуваарилах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг нэмэгдүүлэх замаар санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэн төлөвлөлтийг сайжруулж, төлөвлөсөн хугацаанд хүн амыг суурьшуулан, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг иргэд хүртэх бололцоог бүрдүүлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт

- Хөдөө аж ахуйн кластер байгуулах ажлын хүрээнд багц-5 “Шинэ суурьшлын бүсийн гадна цэвэр усан хангамж, бохир усны шугамын ажлын материал нийлүүлэх” 735.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээг гүйцэтгэсэн “Алтайн эколог” ХХК ажлыг хийж 2021 онд гүйцэтгэхдээ Топазеро цэвэрлэх байгууламжийг аймгийн ерөнхий архитектороос өгсөн координатаас өөрчилж, ерөнхий төлөвлөгөөгөөр 4 айл өрхөд олгох газрын байршилд байрлуулж, угсарсан байна.

Цаашид дээрх зөрчил нь эрсдэл дагуулахаар байгаа тул цэвэрлэх байгууламжийг төлөвлөсөн суурьшлын бүсээс гаргаж, зөвшөөрөгдөх координатад байгуулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

1.2.4. Шинэ суурьшлын бүс бий болсноор орон нутагт үзүүлэх эерэг үр дүнг урьдчилсан тооцоолсон байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 16/01 дүгээр тогтоолын хавсралтаар 2300 өрхийн 8000 орчим хүн амыг суурьшуулж, эхний ээлжийг 2018-2024 онд 3900 хүн, 2 дугаар ээлжийг 2024-2028 онд өссөн дүнгээр 8100 хүн суурьшуулахаар төлөвлөсөн байна.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх, засаг захиргаа, нийгмийн үйлчилгээний барилга байгууламж, дэд бүтцийг шийдвэрлэснээр 1406 өрхийн амины сууц, 188 өрхийн таунхаус, 528 өрх айлын орон сууц, 2300 орчим өрхийн орон сууцны хороолол, цэцэрлэгт хүрээлэн, спорт амралтын талбай, инженерийн дэд бүтцийн эх үүсвэр, түүний шугам сүлжээний төлөвлөлтийг хийснээр орон нутгийн эрчимтэй хөгжлийг хангах, хүн амын суурьшлын бүсийг тэлж, хүн амын ая тухтай ажиллаж амьдрах нөхцөлийг сайжруулахаар үр дүнг тооцож төлөвлөсөн байна.



Аудитаар Баянхонгор сумын хүн амын өсөлтийг статистикийн урьдчилсан тооцооллоор дүн шинжилгээ хийж үзэхэд 2020 оны 31,948 хүн ам 2030 онд 36,820 хүн амтай болохоор байгаа нь Баянхонгор сумын нийт иргэдийн 21.7 хувийн ачаалал тухайн бүсэд ногдохоор байна.

БҮЛЭГ 2. ШИНЭ СУУРЬШЛЫН БҮСИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙН ТЭЗҮ, ЗУРАГ ТӨСВИЙГ МАГАДЛАЛААР БАТАЛГААЖУУЛАЛГҮЙ ТӨСӨВТ БАТАЛСНААС ГЭРЭЭНД ЗААСАН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭГ ӨӨРЧЛӨХ, ТӨСӨВ НЭМЭГДЭХ ЗЭРЭГ СӨРӨГ ҮР ДАГАВАР ҮҮСЭЖ БАЙНА.

2.1. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийхдээ Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтыг зөрчсөн байна.

2.1.1 Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээ шийдвэрлэгдээгүйгээс эмнэлэг, сургуулийн барилгын техникийн нөхцөлийг мэргэжлийн байгууллагууд олгоогүй байна.

Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, хандиваар 2019-2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 5 төсөл, арга хэмжээнд газрын зөвшөөрлийг авсан, техникийн нөхцөлийг Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах арга хэмжээний хүрээнд Ингэний сүүний үйлдвэр, Мах, хүнсний ногооны 1000 тонны зоорины барилгын ажилд мэргэжлийн байгууллагаас техникийн нөхцөлүүдийг авсан байна.

Харин 640 хүүхдийн сургуулийн барилга, 14 ортой эмнэлгийн барилгын ажил нь баригдаж эхлэх 2019 онд инженерийн шугам сүлжээ шийдвэрлэгдээгүйгээс техникийн нөхцөл гаргуулаагүй байна. Энэ талаар мэргэжлийн байгууллагуудаас тодруулахад шинэ суурьшлын бүсэд шугам сүлжээ хийгдээгүй, эх үүсвэр тодорхойгүй байсан тул техникийн нөхцөл олгох боломжгүй байсан гэсэн тайлбар өгсөн.

2.1.2 Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийхдээ Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөөнд батлагдсаны дагуу улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, хандиваар 2019-2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээнээс зураг төсөв шаардлагатай төсөл, арга хэмжээ нь техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан эсэхийг аудитын явцад авч үзэхэд аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлаас бусад нь Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй байна.

Хүснэгт 4. Зураг төсөл болон магадлалын дүгнэлтийн мэдээлэл

№	Эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөл, арга хэмжээний зураг төсөл боловсруулахтай холбоотой мэдээлэл		Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалттай нийцсэн эсэх	Тайлбар
			Эхлэх	Дуусах	Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар баталсан огноо	Магадлалын ерөнхий дүгнэлтийн огноо		
1	2	3	4	5	6	7	8	9

1	Улсын төсөв	Сургуулийн барилга, 640 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/	2019	2020	2019.04.17	2019.05.24	Үгүй	2018.11.02-ний өдөр ТТХ-иар баталсан
2	Улсын төсөв	Эрүүл мэндийн төвийн барилга, 14 ор /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/	2019	2019	2019.04.17	2019.05.24	Үгүй	
3	Улсын төсөв	"Цэвэр хот" төсөл хэрэгжүүлэх ажлын хүрээнд Шинэ суурьшлын бүсийн гадна цэвэр усан хангамж, бохир усны шугамын ажлын материал нийлүүлэх	2021	2021	2020.03.18	2021.01.10	Үгүй	2020.11.13-ны өдөр ТТХ-иар баталсан
4	Улсын төсөв	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/-ингэний сүүний үйлдвэрийн барилгын ажил	2021	2022	2019.03.13	2021.09.24	Үгүй	
		Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/ мах, хүнсний ногооны 1000 тонны агуулахын барилга	2021	2022	2021.06.22	2021.08.24	Үгүй	
		Шинэ суурьшлын бүсийн гадна цэвэр усан хангамж, бохир усны шугамын ажлын материал нийлүүлэх ажил	2021	2022	2020.03.18	2021.01.10	Үгүй	
		Шинэ суурьшлын бүсийн гадна холбооны шугам материал нийлүүлэх	2021	2022	2020.03.18	2021.01.10	Үгүй	
5	Улсын төсөв	Аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээ /Баянхонгор, Баянхонгор сум/	2022	2023	2020.03.18	2021.01.10	Тийм	2021.11.12-ны өдөр ТТХ-иар баталсан
6	Улсын төсөв	Аймгийн шинэ суурьшлын бүсийн хатуу хучилттай авто зам, 10 км /Баянхонгор, Баянхонгор сум/	2022	2024	2021.10.13	2021.12.09	Үгүй	

Эх сурвалж: 2019-2022 оны Төсвийн тухай хууль, ТАХ-ны магадлалын ерөнхий дүгнэлтүүд

Дээрх төсөл, арга хэмжээнээс 8 нь улсын төсөв батлагдсанаас хойш магадлалаар баталгаажуулсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтыг хэрэгжүүлээгүй тул "Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-нд хийсэн гүйцэтгэлийн аудитаар зөрчлийг арилгах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2020 онд хэрэгжүүлэх 5,166.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 640 хүүхдийн сургуулийн барилгын ажлыг гүйцэтгэхээр "Хөх бүрдний эх" ХХК 4,995.4 сая төгрөгөөр шалгарч ажлыг гүйцэтгэсэн боловч Баянхонгор аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/720 дугаар захирамжаар тендерийн хэмнэлт болох 170.9 сая төгрөгөөр барилгын зураг төсөвт дутуу тусгасан сургуулийн гаднах төмөр хашаа, явган замын хавтангийн ажил зэргийг гүйцэтгүүлэхээр нэмэлт ажлын гэрээг байгуулжээ.

- Баянхонгор сумын 14 ортой Эрүүл мэндийн төвийн 1013.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий барилгын ажлыг гүйцэтгэхээр "Хан халдун" ХХК 908.3 сая төгрөгөөр шалгарсан бөгөөд уг тендерийг анх зарлахдаа зөвхөн барилгажих талбайгаар зарласан бөгөөд гадна цахилгааны холболт, бохирын гаргалгаа, бохирын шугам, бохирын цооног гаргах, дулааны шугам татах ажлууд нь

шийдвэрлэгдээгүй тул тендерийн хэмнэлт болох 103.1 сая төгрөгөөр барилгын гадна инженерийн төв магистрал шугам татах, цэвэр усны шугам татах, худаг гаргах, хашаа барих, явган замын гэрэлтүүлэг хийх, авто машины зогсоол хийх зэрэг нэмэлт ажлын гэрээг уг компаниар гүйцэтгүүлэхээр 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан байна.

Дээрхээс харахад зураг төсвийг иж бүрэн зохиогоогүйгээс нэмэлтээр ажлууд хийгдэж төсөвт ачаалал үүсэж байгаа бөгөөд энэ нь Барилга хот байгуулалтын сайдын 2020.02.05-ны өдрийн 30 дугаар тушаалаар баталсан “Барилгын төсөв зохиох дүрэм”-ийн 4.54³ дэх заалттай нийцэхгүй байна.

Цаашид барилга байгууламжийн зураг төсвийг хууль журамд нийцүүлэн иж бүрэн зохиож, төсөвт ачаалал үүсгэхгүй байхад анхаарч, ажлын тоо хэмжээг төсөвт бүрэн тооцож байгаад хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Шинэ суурьшлын бүсэд хийгдэх зарим ажлын зураг төсөв байхгүй, хөрөнгө оруулалтыг бүрэн шийдэж чадахгүй, улс орон нутгийн төсөвт батлагдсан хөрөнгө оруулалтын хүрээнд ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж байна.

Аудитын илрүүлэлт

- “ДНТ” ХХК-ний гүйцэтгэсэн инженерийн хангамжийн шугам сүлжээний зураг төслийн үнийн 200.0 сая төгрөгийн өртөгт гадна цахилгаан хангамжийн зураг төсөл гүйцэтгэх төсөв багтаагүйгээс Шинэ суурьшлын бүсийн гадна шугам сүлжээний цахилгааны зураг төсөл хийгдээгүй, техникийн нөхцөл гараагүй байна.

Үүний улмаас шинэ суурьшлын бүсэд цахилгааны ажлыг трассгүй, зураг төсөвгүй гүйцэтгэсэн нь Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.25 дахь заалтыг зөрчиж байна.

Цахилгааны ажлыг аймгийн ерөнхий архитектораас өгсөн чиглэлийн дагуу гүйцэтгэж байгаа, төсөв батлагдаагүй ажлыг урьдчилан хийснээр ажлын тоо хэмжээ технологийн горим зэрэгт хяналт бүрэн тавихгүй байх зэрэг үр дагавар үүссэн байж болзошгүй тул цахилгаан шугам сүлжээний ажлын зураг төсвийг батлуулж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Орон нутгаас шинэ суурьшлын бүсэд хийгдэх ажлуудын материалыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэж, хийгдэж буй ажлыг мэргэжлийн байгууллагууд болох орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлэн, төсвийн хөрөнгийг хэмнэсэн ч зураг төсөвт тусгагдсан ажлууд бүрэн хийгдэхгүй байх, зураг төсвийн дагуу хийгдэхгүй байх, чанаргүй хийгдэх эрсдэлтэй байгаа тул цаашид хийгдэж арга хэмжээний тендерийг ажил гүйцэтгэх нөхцөлөөр зарлаж, мэргэжлийн байгууллагуудаас тавих хяналтыг сайжруулах нь зүйтэй тул аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлэв.

2.2. Тендерийн үнэлгээний хороо төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа хууль, журмыг баримталж ажиллаагүй байна.

2.2.1 Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 1,303.8 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчсөн байна.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газар нь төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа цахим хэлбэрээр зохион байгуулсан нь ил тод,

³ Барилгын тусгай ажилд дотор сантехник, гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмж, автоматик, холбоо, дохиолол гэх мэт ажлууд, барилгын талбайн ажилд тохижилт, гадна шугам сүлжээ, зам талбай гэх мэт ажлууд хамаарна.

нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, худалдан авах ажиллагааны тайлан, үр дүнгийн талаарх мэдээллийг тухай бүр “tender.gov.mn” сайтад байршуулсан байна.

Шинэ суурьшлын бүсэд улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх 34,813.3 сая төгрөгийн 14 төсөл арга хэмжээний хүрээнд 15 төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалт, 50.0 сая төгрөгийн нэг төсөл арга хэмжээг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмаар зохион байгуулж, 32,218.5 сая төгрөгөөр төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гэрээ байгуулж, төсөвт 60.2 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна.

Харин 1,303.8 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүргүүлэхдээ ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчсөн байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт

- “Цэвэр хот” төсөл хэрэгжүүлэх /Баянхонгор, Баянхонгор сум/- Шинэ суурьшлын бүсийн гадна цэвэр усан хангамж, бохир усны шугамын ажлын материал– нийлүүлэх “Базардарь” ХХК нь тендерийн баримт бичгийн ТШӨХ 18.2 “2019,2020 онуудын аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 60 хувиас багагүй хэмжээний ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байвал зохино. Гэрээг хавсарган ирүүлнэ” гэсэн шалгууруудыг хангаагүй байхад үнэлгээний хорооны олонхын шийдвэрээр (үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлээс) уг компанийг шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 14 дүгээр зүйлийн 14.3.1, 15.3.4 дахь заалтуудыг зөрчсөн;

- Мод үржүүлгийн газар байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны нэг гишүүн ирүүлэх материалууд дутуу шалтгаанаар “Даяар трейд” ХХК-аас татгалзсан байхад 4 гишүүн тус компанийг шалгаруулсан байгаа нь ТБОНӨХБАҮХАТ-ийн 27 дугаар зүйлийн 27.4⁴, тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн 17.6.5 -т заасныг зөрчсөн;

- Шинэ суурьшлын бүсэд усалгааны систем, хамгаалалтын хашааны материалыг нийлүүлэх тендерийн үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нь “Би Эйч Энд Ди” ХХК-ийн банканд байршуулсан тендерийн баталгааны хүчинтэй хугацаа тендерийн хүчинтэй хугацаанаас хойш 28 хоног буюу нийт 58 хоног байна гэсэн шаардлагыг хангаагүй, тендерийн баримт бичигт шаардлага хангасан тендерийн баталгаа ирүүлээгүй тохиолдолд тендерээс захиалагч татгалзах эрхтэй гэж заасныг үндэслэн дахин нээлттэй тендер зарлах саналыг гаргаж татгалзсан байхад тендерийн хорооны 3 гишүүн өмнөх онд цөлжилт газрын доройтолд өртсөн газарт зориулсан санхүүжилт 2 удаагийн тендер амжилтгүй болж татагдсан тул шалгаруулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.11, 20 дугаар зүйлийн 20.52 заасныг зөрчсөн байна.

Иймд цаашид үнэлгээний хороо нь хууль, журмыг зөрчсөн шийдвэр гаргадаг байдлыг таслан зогсоож хууль зөрчсөн саналыг дэмжсэн үнэлгээний хорооны гишүүдэд хариуцлага тооцох албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт

“Даяар трейд” ХХК нь тендерт 127.7 сая төгрөгийн үнийн саналаас 3.8 сая төгрөгийн үнийн хөнгөлөлт үзүүлж, 123.9 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн байхад үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга, аймгийн ОНӨГ-ын мэргэжилтэн Н.Энх-Амгалан нь үнэлгээний хорооны зөвлөмж, гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлд үнийн хөнгөлөлтийг тооцолгүй, 127.7 сая төгрөгөөр гэрээ байгуулах саналыг аймгийн ЗДТГ-т хүргүүлж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.92, 4.2.33 заалтыг зөрчсөн байгаа тул үнийн хөнгөлөлтийн 3.8 сая төгрөгийг “Даяар трейд” ХХК-аар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Мөн 7,032.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээ”-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үнэлгээний хорооны шийдвэрийг зөвшөөрөөгүй оролцогчийн Сангийн яамны эрх бүхий этгээдэд

⁴ Энэ хуулийн 27.3-т зааснаас бусад тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэж захиалагч уг тендерээс татгалзана

гаргасан гомдол нь 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр гомдол гаргагчийн талд шийдвэрлэгдсэн байгаа нь үнэлгээний хороо нь хууль, журмыг бүрэн мөрдөөгүйгээс хүчин төгөлдөр бус хууль зөрчсөн шийдвэр гаргасан байна. Энэ талаар “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитаар зөрчлийг илрүүлж, зөвлөмж хүргүүлсэн.

2.2.2. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх уралдаант сонгон шалгаруулалтыг хуульд заасан шаардлагын дагуу зохион байгуулсан эсэхийг нотлох боломжгүй байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 07 дугаар сарын 02-ний өдрийн 86 дугаар тогтоолоор “Шинэ суурьшлын бүсэд баригдах халаалтын тогооны барилга, шугам сүлжээний нээлттэй төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах” ажлыг баталж, сонгон шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн дотор зарлаж, шуурхай зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгасан байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А/457 дугаар захирамжаар Баянхонгор аймгийн Шинэ суурьшлын бүсийн дулаан үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна. Тус ажлын хэсэг нь 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 5/1094 тоот албан бичгээр “Марал гүн” ХХК, “Их бадарсан” ХХК, “Баянхонгор эко дулаан” ХХК-дад урилга хүргүүлсэн.

Урилгын дагуу “Их бадарсан” ХХК, “Баянхонгор эко дулаан” ХХК-ууд материал ирүүлснийг ажлын хэсэг үнэлгээ хийснээс өөр гаргасан шийдвэр болон шалгарсан оролцогчийн талаарх материалуудыг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс ирүүлээгүй тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

Шинэ суурьшлын бүсийн дулаан үйлдвэрлэгчээр шалгарсан “Баянхонгор эко дулаан” ХХК нь өөрийн хөрөнгөөр уурын зуух барьж, айл өрх, албан газруудыг дулаанаар хангаж байна.

Иргэдийн амьдрах орчныг сайжруулах, агаарын бохирдлыг бууруулах, орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн, орон нутгийн онцлогт тохирсон, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй амины орон сууцны жишиг хорооллыг байгуулах зорилгоор 140 айлын эдлэн газартай “Амины орон сууцны хороолол” төслийг хэрэгжүүлэхээр төсөл сонгон шалгаруулалтыг Нээлттэй засаг-Нэг Баянхонгор цахим хуудсаар 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр хүртэлх хугацаанд зарлаж, материалыг Баянхонгор аймгийн ГХБХБГ-т хүлээн авсан байна.

Аймгийн ГХБХБГ-ын холбогдох мэргэжилтнээс тодруулахад уг төсөл сонгон шалгаруулалтыг эхний удаа зарлахад оролцогч ирээгүй, хоёр дахь удаагаа зарлахад нэг оролцогч материалаа ирүүлсэн гэх боловч сонгон шалгаруулалтын үр дүн гараагүй гэсэн тайлбарыг өгсөн.

Дээрх сонгон шалгаруулалтуудтай холбоотой мэдээлэл, үр дүнг аймгийн ИТХ-ын хуралд танилцуулан, хэлэлцүүлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2.3. Зарим төсөл арга хэмжээг гүйцэтгэхдээ тендерт зарласан анхны зураг төсвийг өөрчлөн гүйцэтгэсэн байна.

2.3.1. Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийж байгаа төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ-г төсөв баталснаас хойш хийснээс шалтгаалан тендер зарласан ажлын тоо хэмжээг өөрчилж байна.

1. Сургуулийн барилга, 640 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2020 онд хэрэгжүүлэх 5,166.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын ажлыг гүйцэтгэхээр "Хөх бүрдний эх" ХХК 4,995.4 сая төгрөгөөр шалгарч 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гаргаж хүлээн авч комисс дутуу ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулсан байна.

Аудитын илрүүлэлт

- Нэмэлт гэрээгээр хийгдэх 86.5 сая төгрөгийн нэр бүхий 8 ажлыг 2022 оны 06 дугаар сарын 22-ний дотор хийж гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн ч тус ажлууд хийгдээгүй байна. Мөн барилгын гадна талын фасадын зарим хэсэг хуурч унасан, цонх дулаан алдалт ихтэй, номын сан болон урлагийн заалнууд маш хүйтэн байдаг талаар ашиглагч байгууллагаас санал ирсэн байна.

Иймд зураг төсөвт тусгагдсан "Барилгын үлдэгдэл ажил гүйцэтгэх гэрээ"-ний дагуу 86.5 сая төгрөгийн нэр бүхий 8 ажлыг "Хөх бүрдний эх" ХХК хийж гүйцэтгээгүй байгаа тул зөрчлийг арилгах албан шаардлагыг Баянхонгор аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2. Эрүүл мэндийн төвийн барилга, 14 ор

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх 1,013.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 ортой эрүүл мэндийн төвийн барилгын ажлыг гүйцэтгэж "Хан халдун" ХХК 1,011.4 сая төгрөгөөр гүйцэтгэж 2019 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарган улсын комисс хүлээн авсан байна.

3. "Цэвэр хот"- Шинэ суурьшлын бүсийн гадна цэвэр усан хангамж, бохир усны шугамын ажлын материал нийлүүлэх

Аймгийн Засаг дарга "Базардарь" ХХК-тай 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдөр 2021/114 дүгээр Баянхонгор аймгийн Шинэ суурьшлын бүсийн гадна цэвэр, бохир усны материалыг 2021.05.14-өөс 2021.11.20-ны өдрийн хороонд нийлүүлэх гэрээг 995.0 сая төгрөгөөр байгуулж бараа материалыг нийлүүлж санхүүжилтээ бүрэн авсан байна.

"Чандмань - Баянхонгор" ХК

Тус байгууллага нь гадна цэвэр ус хангамжийн 9000 метр шугам угсрах, 500 м³ усан сангийн угсралт, гадна ариутгах татуургын 700 метр шугам угсрах, цэвэр усны системд дахин дамжуулах насос станцын барилга, насос станц монтажлах, ариутгах татуургын системд өргөх насос станцын барилга, насос станц угсрах гэх мэт ажлуудыг

хийж гүйцэтгэсэн байна. Дээрх ажлын хөлсөнд 252.6 сая төгрөгийн төсөв төсөвлөсөн бөгөөд 225.1 сая төгрөг батлагдаж “Хонгор тогтвортой хөгжил” ТББ-аас 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр 39.6 сая төгрөг олгосон, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 15/42 дугаар тогтоолоор шинэ суурьшлын бүсийн цэвэр усны шугам сүлжээний ажлын зардалд 180.0 сая төгрөгийг аймгийн ОНХС-аас олгохоор баталж 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр 80.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

“Ундрахпик” ХХК

Тус аж ахуйн нэгж нь Шинэ суурьшлын бүсэд 250 м³ усан сан барихаар төлөвлөгдсөн бөгөөд усан сангийн хэмжээг нэмэгдүүлэн 500 м³ болгон барьж гүйцэтгэн ажлын хөлсөнд “Монгол болгар гео” ХХК-иас 15.6 сая төгрөгийг олгосон байна.

“Хаш гоёо” ХХК

Цэвэр усны худгийг автоматжуулах ажлыг гүйцэтгүүлж ажлын хөлсөнд “Эрдэнэ монгол” ХХК-аас 25.0 сая төгрөгийг олгосон байна.

“Талын нөмөр” ХХК

“Талын нөмөр” ХХК-ийн төрийн аудитын байгууллагад ирүүлсэн ажил гүйцэтгэсэн тайландаа “Цэвэр ус татах 4.5 км урттай, 3 метр гүнтэй, 1.4 см өргөнтэй тууш ухаж нийт 18,900 м³, бохирын шугамын 1.5 км урттай, 3 метр гүнтэй, 1.4 см өргөнтэй 6300 м³ шороог ухаж, булах, шинэ суурьшлын хойд бэлд 14:14 харьцаатай 4 метр гүнтэй усан сангийн нүхийг ухах, булах 588 м³ газар шорооны ажлыг гүйцэтгэсэн” гэж ирүүлсэн байна. Дээрх ажлын хөлсөнд Баянхонгор аймгийг хөгжүүлэх 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд 104.2 сая төгрөг тусгасан бөгөөд “Топ ган дриллинг” ХХК 30.0 сая, “Эрдэнэ монгол” ХХК 74.2 сая нийт 104.2 сая төгрөгийн ажлын хөлс олгосон байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А/459 дүгээр захирамжаар “Цэвэр хот” төслийн хүрээнд шинэ суурьшлын бүсийн гадна цэвэр усан хангамж, бохир усны шугамын 104.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг гүйцэтгүүлэн 2021 оны 07 дугаар сарын 24-ний өдөр хүлээн авсан байна.

Шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд 100 м³ хоёр усан сан хийхээр төлөвлөснийг 250 м³-ийн 2 усан болгон өөрчилж хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт

Усан сангийн хамгаалалтын хашаа, торон хашаа, харуулын байр, насос станцын барилгын ажил төсөвт туссан боловч усан сангийн хүчин чадлыг нэмэгдүүлснээс тухай ажил хийгдээгүй байгаа нь эрүүл ахуй, аюулгүй байдалд эрсдэл учирч болзошгүй нөхцөл байдал үүсэж байгаа тул Хот суурины усан хангамж, ариутгах татуургын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1⁵ дэх заалтыг зөрчиж байна.

Иймд усны эх үүсвэрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангаж Хот суурины усан хангамж, ариутгах татуургын тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

⁵ 17.1. Улсын онц чухал объектод хамаарах ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтыг дотоодын цэрэг гүйцэтгэж, бусад ус хангамжийн эх үүсвэр нь энгийн харуул хамгаалалттай байна.

4. Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер багц 1: Ингэний сүүний үйлдвэрийн барилгын ажил

Аймгийн Засаг дарга “Базардарь” ХХК-тай 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр 3,848.1 сая төгрөгөөр “Баянхонгор аймгийн ингэний сүүний үйлдвэр байгуулах ажлын захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээ”-г 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд гүйцэтгэхээр байгуулж, 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр барилгыг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарсан байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/263 дугаар захирамжаар Ингэний сүүний үйлдвэрийг ашиглалтад орох хүртэлх хугацаанд удирдлага зохион байгуулалтаар хангах ажлын хэсгийг 8 хүнтэй байгуулснаар тус ажлын хэсэг нь ингэний сүүний үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмжийн үнэнд судалгаа хийж тоног төхөөмжийн үнэ өссөн, техникийн тодорхойлолт боловсруулахдаа судалгаа дутуу хийснээс зарим арга хэмжээг санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн зэргийг дүгнэсэн байна.

Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/305 дугаар захирамжаар дээрх 6 ажлыг 3 болгон дараах байдлаар өөрчилсөн байна.

Хүснэгт 5. Ингэний сүүний үйлдвэрийн гэрээнд тусгасан ажлууд

№	Гүйцэтгэх ажил, арга хэмжээ	Аймгийн Засаг дарга “Базардарь” ХХК-тай 2021.09.08-ны өдөр байгуулсан 2021/188 дугаар гэрээ		Аймгийн Засаг даргын 2023.05.31-ний өдрийн А/305 дугаар захирамжийн хавсралт	
		Тоо хэмжээ	Төсөвт өртөг	Тоо хэмжээ	Төсөвт өртөг
1	Ингэний фермийн саах байр	1	480.5	-	-
2	Ингэний фермийн байрлах байр	2	593.4	-	-
3	Сүүний үйлдвэрийн барилга	1	1,046.4	1	1,287.7
4	Автомашин	4	215.0	-	-
5	Ажилчдын байр	1	319.9	-	-
6	Тоног төхөөрөмж	-	1,192.9	-	2,527.6
7	Үйлдвэрийн гадна тохижилт	-	-	-	32.8
	Нийт төсөвт өртөг		3,848.1		3,848.1

Эх сурвалж: АЗД-ын “Базардарь” ХХК-тай байгуулсан гэрээ, АЗД-ын 2023 оны А/305 дугаар захирамж

Аудитын хугацаанд буюу 2023 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр талбар дээр ажиллахад барилгын гадна тохижилтын ажил хийгдээгүй, “Базардарь” ХХК ингэний сүүний үйлдвэрийн худалдан авсан тоног төхөөрөмжийг угсарч суурилуулаагүй тул техникийн тодорхойлолттой тулгах боломжгүй байсан ба 2023.09.22-нд суурилагдаж эхэлсэн байна.

5. Хөдөө аж ахуйн кластер багц 2: Ногоон тэжээлийн үйлдвэр

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хөдөө аж ахуйн кластер байгуулах төсөл арга хэмжээнд 12,000.0 сая төгрөг батлагдсаны 2-р багцад 2,584.8 сая төгрөгийн төсөв хуваарилан “Ногоон тэжээлийн үйлдвэр” барихаар 2 удаа нээлттэй тендер зарласан боловч оролцогч оролцоогүйгээс 2022 оны 05 дугаар сарын 03-ний өдөр “Бэнжцэс” ХХК-тай 2,584.8 сая төгрөгөөр 2023 оны 05 дугаар сарын 05-

аас 2024 оны 08 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэхээр “Ногоон шим” шууд гэрээ байгуулан ажилласан байна.

Тухайн төсөл арга хэмжээнд төсөв хуваарилах үед зураг, төсөв магадлалаар баталгаажуулаагүй байсан бөгөөд төсөв магадлалаар баталгаажихад төсөл арга хэмжээ 4,307.0 сая төгрөг болон төсөв нэмэгдэж төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх хүндрэл учирч эхэлсэн байна.

Уг төслийг талаар аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, ХБТБОХ-ийн дарга, Хөдөө аж ахуйн газрын дарга, ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга болон гүйцэтгэгч “Бэнжцэс” ХХК-ийг захирлыг байлцуулан хуралдаж ажилчдын байр, агуулах, хүлэмжтэй гадна хашаатай тэжээлийн цех байсныг 100*10 хэмжээтэй 2 ширхэг, 1*40 хэмжээтэй 1 ширхэг 2400 м.кв гурван ширхэг хүлэмж барихаар шийдвэрлэсэн байна.

Аудитаар газар дээр нь очиж үзэхэд 100*10 хэмжээтэй 2 хүлэмжийн суурийн болон хана, хамар ханын ажил, хаалга, цонхны хийгдсэн гадна фасадыг хөөсөөр дулаах, гадна дотор заслын ажил хийгдэж байв. Зохиогчийн хяналтын 2023.09.05-ний нэгдсэн дүгнэлтээр “Тухайн барилгын суурь, өрлөг, зүрхэвч, бүс бетон, төмөр деталиуд зургийн дагуу хийгдсэн байна” гэж дүгнэжээ.

6. Хөдөө аж ахуйн кластер багц 3: Мах, хүнсний ногооны 1000 тонны агуулахын барилга

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын даргын 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/102 дугаар тушаалаар “Баянхонгор аймгийн Хөдөө аж ахуйн салбарын (Ногоон тэжээлийн үйлдвэр, Ингэний сүүний үйлдвэр, 1000 тонн мах, ногооны зоорь, дэд бүтэц) үнэлгээний хороо байгуулж, 9 хүний бүрэлдэхүүнтэй тус хороо ХХААХҮЯ/202102037 дугаартай тендерийг 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдөр үнэлж, багц 3 буюу мах, ногооны зоорь, бойны газрын ажилд “Сант-Өндөр” ХХК 3,074.9 сая төгрөгийн үнийн санал ирүүлснийг шалгаруулан, 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдөр 2021/140 тоот гэрээг аймгийн Засаг даргатай байгуулжээ.

Аймгийн Засаг дарга, “Сант-Өндөр” ХХК-ийн хооронд байгуулсан гэрээнд малын мах, махан бүтээгдэхүүн, ногоо, хагас болон гүн хөлдөөх хөргүүр бүхий 1000 тонны хүчин чадалтай зоорины барилгыг 2,551.4 сая, бойны газрын барилгыг 523.5 сая төгрөгөөр гүйцэтгэхээр заасан бөгөөд тендер зарлах үед ажлын зураг төсөв магадлалаар батлагдаагүй байсан, мах, ногооны 1000 тонны зоорины барилгын ажлын зураг төсвийг Барилгын хөгжлийн төвийн 2021 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 1242/2021 тоот магадлалын ерөнхий дүгнэлтээр нийт төсөвт өртгийг 4,869.2 сая төгрөгөөр буюу гэрээний дүнгээс 2,317.8 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа тул барилгын ажлыг бүрэн дуусгаж ашиглалтад оруулахад шаардлагатай зураг төсвийн үнийн зөрүүг 2024 оны төсөвт тусгуулах саналыг тавьж байгаа гэсэн тайлбарыг “Сант-Өндөр” ХХК-аас ирүүлсэн.

Гэрээний 2.1-т ажлын нийт үнэ 3,074.9 сая төгрөгөөс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд 500.0 сая, 2022-2023 онд үлдэгдэл 2,574.9 сая төгрөгийг санхүүжүүлэхээр заасан ч, 2021 оны төсвийн тодотголоор баталсан төсөв танагдсан тул аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын газарт 1А/689 дүгээр албан бичгийг хүргүүлэн, тус ажилд 2021 онд 250.0 сая төгрөгийг хуваарилсныг мэдэгдэж, тус ондоо санхүүжилтийг олгож,

2022 онд 950.0 сая, 2023 оны 08 дугаар сарын 17-ны өдөр 810.3 сая, нийт 2,010.4 сая төгрөгийг олгосон нь нийт зардлын 65.4 хувийг авсан байна.

Баянхонгор аймагт мах, ногооны зоорь, бойны газрын барилга угсралтын ажлыг гүйцэтгэх захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний 3.1⁶-т заасан хугацааг мөрдөөгүй, ба нэмэлт гэрээг 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр 2023-НЭ-08 гэрээг байгуулж, 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр дуусгахаар өөрчилсөн ба аудитын явцад тус барилга дээр очиход шалны тэгшилгээ хийгдэж байсан, гүйцэтгэгч компаниас ажлын гүйцэтгэлийг 66.5 хувьтай тайлагнаж, сүүлийн санхүүжилтийг 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр авсан байна. Гэрээнд заасны дагуу санхүүжилтийг тухайн онд бүрэн авсан бол ажлыг бүрэн хийх боломжтой байсан гэсэн тайлбарыг гүйцэтгэгчээс ирүүлсэн болно.

Бойны газар байгуулах зөвшөөрлийн асуудал шийдэгдээгүйгээс зураг, төсөв хийгдээгүй тул барилга эхлээгүй байна.

Тус зоорины барилга ашиглалтад орсноор аймгийн газар тариалан эрхлэгчид болон малчид зориулалтын стандарт агуулахтай болж, тарьсан ногоо, малын мах, түүхий эдээ удаан хугацаанд хадгалж чадахгүй байх эрсдэлээс гарах боломжтой болохоор байна.

7. Хөдөө аж ахуйн кластер багц 4: Шинэ суурьшлын бүсийн гадна холбооны шугам материал нийлүүлэх

Аймгийн Засаг дарга "Нью бест хаус" ХХК-тай 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Шинэ суурьшлын бүсийн гадна холбооны шугам материалыг 2021 оны 07 дугаар сарын 09-өөс 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хооронд нийлүүлэх гэрээг 808.2 сая төгрөгөөр байгуулж 691.0 сая төгрөгийн санхүүжилт авсан байна

"Нью бест хаус" ХХК нь гэрээний хугацаанд ажлыг бүрэн гүйцэтгээгүй бөгөөд 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдөр гэрээг 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдөр хүртэл, дахин 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдөр 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдөр хүртэл 2 удаа сунгасан байна.

Аудитын илрүүлэлт

- Техникийн тодорхойлолтод тусгагдсанаар "Нью бест хаус" ХХК нь нэг барилга, 126 худаг, 30 нэр төрлийн бараа материал нийлүүлэхээс "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-д 20 нэр төрлийн бараа материалыг хүлээлгэн өгч нэг барилга, 126 худгийг хүлээлгэн өгөөгүй, 10 нэр төрлийн бараа материалыг нийлүүлээгүй тул ажлыг бүрэн гүйцэтгүүлж хүлээн авах албан шаардлагыг аймгийг Засаг даргад хүлгүүлэв.

"Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК нь Шинэ суурьшлын бүсийн гадна холбооны угсралтын ажлыг гүйцэтгэхээр аймгийн Засаг даргатай 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр 95.0 сая төгрөгийн гэрээг байгуулж, бусад эх үүсвэрээр санхүүжүүлэхээр тусгасан ч тус байгууллагад 7.3 км 48 корын шилэн кабелийн ажлыг гүйцэтгүүлсэн атлаа 24.2 сая төгрөгийн ажлын хөлсийг олгосон байна.

⁶ Гүйцэтгэгч нь Монгол улс Баянхонгор аймагт мах, ногооны зоорь, бойны газрын барилга угсралтын ажлыг техникийн тодорхойлолт, төсөвт тусгагдсаны дагуу 2021 оны 07 дугаар сарын 15-ны өдөр эхэлж, 2022 оны 10 дугаар сарын 30-ны өдөр ашиглалтад оруулна.

8. Хөдөө аж ахуйн кластер багц 5: Шинэ суурьшлын бүсэд цэвэрлэх байгууламж ТОПАЭРО төхөөрөмж

Хөдөө аж ахуйн кластер байгуулах ажлын хүрээнд багц-5 “Шинэ суурьшлын бүсийн гадна цэвэр усан хангамж, бохир усны шугамын ажлын материал нийлүүлэх” 735.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 450.0 сая, Орон нутгийн иргэдэд иргэдэд түшиглэсэн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ төслөөс 285.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Дээрх төсөл арга хэмжээнд 2 удаа нээлттэй тендер шалгаруулалт зарласан бөгөөд шаардлагад нийцсэн оролцогч ирээгүй тул “Алтайн эколог” ХХК-тай 735.0 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгүүлж, 2021 оны 10 дугаар сарын 20-ний өдөр барилга байгууламжийг комиссын дүгнэлтээр “ТОПАЭРО цэвэрлэх байгууламж (биологийн цэвэрлэгээний аргад суурилдаг, газар доогуур суурилуулсан тоног төхөөрөмж) хүлээн авч ашиглалтад оруулсан байна.

Одоогоор шинэ суурьшлын бүсэд цэвэр бохир ус хэрэглэгч айл өрх 58, аж ахуйн нэгж байгууллага 2, нийт хоногийн хэрэглээ 24.3м3 байгаа нь ойрын хугацааны хэрэглээг хангаж байгаа ч мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн тайлбараас цаашид хэрэглэгч өсөн нэмэгдэхийн хэрээр цэвэрлэх байгууламжийг өргөтгөх, хамгаалалтын бүсийг тогтоох зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байна.

Аудитын хийх явцад 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр уг байгууламжийн 3-4 блокод гал гарч шатсан бөгөөд мэргэжлийн байгууллагын дүгнэлт гараагүй байна.

9. Хөдөө аж ахуйн кластер багц 6: Цахилгааны эх үүсвэрийн ажил гүйцэтгэх, материал нийлүүлэх

ХАА-н кластерийн Багц 6 буюу “Шинэ суурьшлын бүсийн цахилгаан эх үүсвэрийн материал нийлүүлэх” багцад “Нэмүүн инженер” ХХК материал ирүүлсэн ч шаардлага хангаагүй тул тендерийн үнэлгээний хороо аймгийн Засаг даргад шууд гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Аж ахуйн нэгжүүдэд албан бичиг хүргүүлснээс 2021 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 21/138 дугаар албан бичгээр “Нэмүүн инженер” ХХК тендерт оролцох боломжгүй гэж хариу ирүүлж, “Эн ди эм эм” ХХК-аас 1,195.0 сая, “Баянхонгор эрчим хүч” ЦТХХК-аас 1,220.6 сая төгрөгийн үнийн санал ирүүлснээс “Эн ди эм эм” ХХК шалгарч, 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хөрөнгийг нийлүүлж дуусгахаар гэрээнд тусгаж, аймгийн Засаг даргатай 2021 оны 08 дугаар сарын 11-ны өдөр 2021/171 тоот гэрээг байгуулжээ.

Аудитын явцад ирүүлсэн баримт материалд дээрх гэрээ нь “Эн ди эм эм”-ийн захирал Д.Батбаяр, Д.Батбэх гэсэн нэртэйгээр 3 өөр гэрээ байгаа ба аудитаар улсын бүртгэлийн гэрчилгээ дээр захирлын нэрийг тодруулахад 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс гүйцэтгэх захирлаар Д.Батбэх томилогдсон байна. Аймгийн ЗДТГ-ын мэргэжилтнээс энэ талаар тодруулахад “Улсын төсвөөс олгох санхүүжилт танагдсантай холбоотой гэрээний 2.1 дэх заалтад тусгасан санхүүжилтийн олгох дүнг өөрчилсөн тул гэрээг дахин өөрчилж хийхдээ шинээр томилогдсон захирал Д.Батбэхтэй хийсэн” гэсэн тайлбарыг өгсөн болно.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/543 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэг 2021 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр 811.1 сая төгрөгийн 13 нэр төрлийн тоног төхөөрөмжийг хүлээн авч, актыг үйлдсэн бөгөөд 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр 2022/ХС-02021/171 дугаар гэрээгээр ковид цар тахлын улмаас ажлыг хугацаандаа хийх боломжгүй тул харилцан тохиролцон гэрээний хугацааг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл сунгажээ.

Шинэ суурьшлын бүсийн цахилгаан эх үүсвэрийн 37 нэр төрлийн материалыг 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр “Баянхонгор эрчим хүч” ЦТХХК-ийн 4 албан хаагч хүлээн авч, КТП, УКШ маркийн бетон тулгууруудыг шинэ суурьшлын бүсийн газарт, бусад материалыг компанийн тусад нь агуулахад хадгалж байна.

10. Баянхонгор аймгийн цөлжилт, газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах

Тус арга хэмжээний хүрээнд Хамгаалалтын зурвас байгуулах зардалд БОАЖС-ын 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/34 дүгээр тушаалаар 100.0 сая, орон нутгийн төсвийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 71.0 сая төгрөгийг шийдвэрлэж, “Би Эйч Энд Ди” ХХК-тай 163.9 сая төгрөгийн гэрээ байгуулж, шинэ суурьшлын бүсийн араар 3 метр өргөнтэй, 150 метр урттай нийт 50 га талбайд элсний нүүлтээс хамгаалах, зурвас байгуулах ажлын хашаа хамгаалалт, усалгааны системийн материал нийлүүлэх гэрээг 2021 оны 10 дугаар сарын 30-ны өдөр хүлээн авахаар 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр байгуулж, 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр тус ажлын хэсэг, “Баянхонгор тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын төлөөллийг оролцуулан хүлээн авч, актыг үйлдсэн байна.

“Би Эйч Энд Ди” ХХК-ийн оролцсон тендерийн техникийн тодорхойлолтод торны хэмжээг тодорхой заагаагүй байсан тул тус техникийн тодорхойлолтыг боловсруулсан “Баянхонгор тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын албан хаагчаас тайлбар ирүүлэхийг шаардсан боловч ирүүлээгүй, тус асуудлыг аймгийн Цагдаагийн газар шалгаж, аймгийн Прокурорын газраас АТГ-т шилжүүлсэн байна.

Баянхонгор аймгийн ОНХС-ийн 2023 оны хөрөнгийн 127.7 сая төгрөгийн санхүүжилттэй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд шинэ суурьшлын бүсийн хамгаалалтын ойн зурвасын усалгааны материал нийлүүлэх тендерт “Багц билэгүүд” ХХК 98.7 сая төгрөгөөр нийлүүлэхээр шалгарч, ойн зурвасын усалгааны 20 мм хоолойг 90,000 метр, 110х40 хоолойн холбогч 50 ширхэг материалыг 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр “Баянхонгор тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгсөн байна.

Шинэ суурьшлын бүсийн усалгааны системийг угсрах ажлыг “Баянхонгор тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ хариуцан гүйцэтгэх явцад 30.8 сая төгрөгийн зардал зарцуулсныг өглөгөөр бүртгэсэн зардлыг олгоогүйгээс ажилтнуудад цалин хөлс олгоогүй гэсэн тайлбар өгсөн тул ажлын хөлсийг олгохыг аймгийн Засаг даргад зөвлөв.

Баянхонгор сумын ОНХС-ийн 20.0 сая, БОАЖГ-ын төсвийн хөрөнгийн 20.0 сая, нийт 40.0 сая төгрөгөөр 2 ширхэг худаг гаргасныг хөрөнгөд орлогод авсан байна.

Байгаль орчны салбарт хандиваар тусламжаар “Мөнх ногоон тал” ХХК-аас 2022 онд 15.1 сая төгрөгийн өртөг бүхий 32 нэр төрлийн 866 ширхэг багаж төхөөрөмжийг аймгийн БОАЖГ хөрөнгөд бүртгэсэн, ойн зурвас дахь модны усалгаа, арчилгаа хийлгэх, усалгааны системийг эвдрэл гэмтэлгүй байлгах, хайс шонгийн бүрэн бүтэн

байдлыг хангах, эвдэрсэн шон хайсыг тогтмол засах, мал амьтнаас хамгаалах зорилгоор 3 иргэнтэй гэрээ байгуулан, иргэдийн цалин урамшуулалд 11.3 сая төгрөгийг байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас олгожээ.

11. Аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээ

“Гал хонгор” ХХК нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлыг 6,961.1 сая төгрөгөөр 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс мөн оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажилласан бөгөөд 2022 онд 480.0 сая, үлдэгдлийг 2023 онд санхүүжүүлэхээр туссан байна.

Гүйцэтгэгч 2022 онд 480.0 сая төгрөгийн гүйцэтгэл гарган санхүүжилт авсан бөгөөд газар шорооны ажил, дулааны сувгийн ажил, дулаан хангамжийн угсралтын ажлыг хийсэн байна.

Аудитаар 2023.09.06-нд газар дээр нь очиж ажиллахад бохирын шугам угсралтын ажлыг 100 хувь хийж гүйцэтгэсэн, цэвэр болон халаалтын шугамын ажлын газар шорооны ажлыг 100 хувь гүйцэтгэсэн, сувгийн болон шугам угсралтын ажлыг хийж гүйцэтгэж байна.

12. Аймгийн шинэ суурьшлын бүсийн хатуу хучилттай авто зам, 10 км

Тус төсөл арга хэмжээний сонгон шалгаруулалтыг 2022 онд зохион байгуулан нээлттэй тендер зарласны үр дүнд 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр “Түмдэлгэрэх” ХХК-тай 7,995.2 сая төгрөгөөр 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан байна.

Аудитаар “Түмдэлгэрэх” ХХК нь 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар замын 8.5 км авто замын далангийн ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд зарим хэсэгт хашлага хийсэн, асфальтан хучилт хийж эхлүүлээд ажлыг зогсоосон байна.

Төсөл, арга хэмжээний зохиогч “Ихэр мөнх” ХХК нь 2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр барилгын ажилд зохиогчийн хяналт хийсэн дүгнэлт гаргасан бөгөөд уг дүгнэлтэд:

1. Авто замын барилгын ажилд зориулж хийсэн буюу дугуй цохигчийг газар дээр нь цутгаж байгалиар нь хатаасан байгаа нь бат бэхийн үзүүлэлтийг хангаж байгаа эсэх эргэлзээтэй тул итгэмжлэгдсэн лабораториор магадлуулах шаардлагатай
2. Буталсан чулуун суурийн материал нь техникийн шаардлагын бүлэг 900-ийн 902, 903 дугаар заалтад заасан материалын ангилал, материалын шаардлагыг хангахгүй байна.
3. Авто замын зарим хэсэгт асфальтан хучилт хийгдсэн байгаа ба асфальт бетон хучилт хийхдээ битум цацлага хийгээгүй мөн авто замын зураг төслийн дагуу өнгө асфальт бетон хучилт 3см, суурь асфальтан хучилт 4 см байсныг нийлүүлэн нэг үе болгож авсан.
4. Зохиогчийн зүгээс авто замын ажлын батлагдсан төсөвт өртөгт тааруулан өөрчлөлт оруулахдаа замын хийцэд болон өргөнд өөрчлөлт ороогүй. Зөвхөн дугуйн зам, явган замын хучилтыг хийхгүйгээр тусгасан байгаа. Одоо хийгдсэн байгаа далангийн өргөн зураг төсөлд заасан хэмжээнд хүрэхгүй байна. Өргөсөлтийг шаталсан хэлбэрээр хийж гүйцэтгэх шаардлагатай.
5. Зам барилгын ажлын шатанд техник технологийн хяналтыг гүйцэтгэж байгаа байгууллагын төлөөллөөс зураг төсөл зохиогчтой хийсэн уулзалтад ирээгүй. Зам тээврийн хөгжлийн сайдын

2018.10.18-ны 228 дугаар тушаалаар баталсан авто, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам, түүний хавсралт баримт бичиг хөтлөөгүй байгаа нь авто замд хийгдсэн далд ажлуудыг шалгах боломжгүй нөхцөл үүссэн

гэж дүгнэсэн байна. Гарсан дүгнэлтийн талаар гүйцэтгэгч талаас тодруулга авахад: “Манайх зураг төслийн дагуу гүйцэтгэж байгаа зохиогч ямар ч лабораторийн шинжилгээгүй дүгнэлт гаргасан бид буталсан чулууг лабораторийн шинжилгээнд явуулсан байгаа” гэсэн тайлбар өгөв.

Иймд төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд зохиогч, захиалагч, гүйцэтгэгчийн байлцуулан гарсан зөрчлийг холбогдох хууль, журмын дагуу арилгах арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

13. Шинэ суурьшлын бүсэд мод үржүүлгийн талбай байгуулах

Баянхонгор аймгийн Шинэ суурьшлын бүсийн дэргэд мод үржүүлгийн талбай байгуулах 130.0 сая төгрөгийн өртөг бүхий ажлын гүйцэтгэхээр “Даяар трейд” ХХК шалгарсан байна. Тус ажлын хүрээнд БОАЖГ-аас техникийн тодорхойлолтыг 2 удаа өөрчилж аж ахуйн нэгжтэй тохиролцон ажлыг гүйцэтгүүлсэн боловч шаардлага хангаагүй гэсэн үндэслэлээр комисс хүлээн аваагүй байна.

Иймд гүйцэтгэсэн ажлыг үнэлж, ажлын гүйцэтгэлийг бүрэн хангуулж хүлээн авах албан шаардлагыг аймгийн БОАЖГ-т хүргүүлэв.

Уул уурхайн компаниудаас өгсөн хандивын 37.4 сая төгрөгөөр “Гоби голден сийдс” ХХК-аас тарьц, суулгац авсныг аймгийн БОАЖГ мод үржүүлгийн талбайд тарьсан боловч, ургаагүй, аймгийн Сум дундын Ойн анги энэ талаар мэдээлэл байхгүй, тухайн байгууллага тус тарьц суулгацыг тарих талбай байсан хэдий ч хүн хүч, услалтын систем хангалтгүй гэсэн тайлбарыг ирүүлсэн. Иймд цаашид шинэ суурьшлын бүсэд байгуулсан Мод үржүүлгийн газрыг аймгийн Сум дундын Ойн ангид шилжүүлж, ажиллах орон тооны боломж нөхцөлийг шийдвэрлэхийг аймгийн Засаг даргад зөвлөв.

14. Шинэ суурьшлын бүсийг эрчим хүчинд холбох /аймгийн ОНХС/

Аймгийн ОНХС-ийн 300.0 сая төгрөгийн хөрөнгөөр шинэ суурьшлын бүсийг эрчим хүчинд холбох ажлыг “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК гүйцэтгэх гэрээг 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдөр гэрээг байгуулж, ажлыг гүйцэтгэсэн байна.

Тус компани Шинэ суурьшлын бүсийг эрчим хүчинд холбох ажилд нийт 311.8 сая төгрөгийн 152 нэр төрлийн материалыг худалдан авч, шатахуунд 6.1 сая, нийт 317.9 сая төгрөгийг зарцуулан, гэрээний дүнгээс илүү зарцуулсан 17.9 сая төгрөгийг 2019 оны зардлаар бүртгэсэн байна.

2.3.2. Санхүүжилтийг гүйцэтгэлд тулгуурлан он тус бүр батлагдсан төсвийг бүрэн олгосон байна.

Шинэ суурьшлын бүсэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 34,300.3 сая төгрөгийн гэрээ байгуулан 20,761.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон бол орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 300.0 сая төгрөгийн гэрээ байгуулан 276.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 102.2 сая, хандивын эх үүсвэр 200.6 сая төгрөгөөр нэмж санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 6. Шинэ суурьшлын бүсийн хөрөнгө оруулалтын санхүүжилт (сая.төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээний дүн	Авсан санхүүжилт	Үлдэгдэл санхүүжилт
1	Сургуулийн барилга, 640 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/	"Хөх бүрдний эх" ХХК	5,166.0	5,144.8	21.2
2	Эрүүл мэндийн төвийн барилга, 14 ор /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/	"Хан халдун" ХХК	1,011.4	1,011.4	-
3	"Цэвэр хот" төсөл хэрэгжүүлэх /Баянхонгор, Баянхонгор сум/- Шинэ суурьшлын бүсийн гадна цэвэр усан хангамж, бохир усны шугамын ажлын материал нийлүүлэх	"Базардарь" ХХК	995.0	989.0	6.0
4	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/- ингэний сүүний үйлдвэрийн барилгын ажил	"Базардарь" ХХК	3,848.1	1,287.7	2,560.4
5	Хөдөө аж ахуйн кластер багц 2: Ногоон тэжээлийн үйлдвэр	"Бэнжцэс" ХХК	2,584.6	559.5	2,025.1
6	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/ мах, хүнсний ногооны 1000 тонны агуулахын барилга	"Сант-Өндөр" ХХК	3,094.4	2,044.8	1,049.6
7	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/ Шинэ суурьшлын бүсийн гадна холбооны шугам материал нийлүүлэх захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээ	"Нью бест хаус" ХХК	811.4	686.8	124.6
8	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/ цэвэрлэх байгууламж- Шинэ суурьшлын бүсэд цэвэрлэх байгууламж ТОПАЭРО төхөөрөмж	"Алтай эколог" ХХК	451.0	450.0	1.0
9	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/ Цахилгааны эх үүсвэрийн ажил гүйцэтгэх, материал нийлүүлэх	"Эн ди эм эм" ХХК	1,210.5	1,195.0	15.5
10	Баянхонгор аймгийн цөлжилт, газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах	"БИ ЭЙЧ ЭНД ДИ" ХХК	99.9	99.9	-
11	Аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээ /Баянхонгор, Баянхонгор сум/	Гал хонгор ХХК	7,032.9	3,482.1	3,550.8
12	Аймгийн шинэ суурьшлын бүсийн хатуу хучилттай авто зам, 10 км /Баянхонгор, Баянхонгор сум/	"Түм дэлгэрэх" ХХК	7,995.2	3,810.8	4,184.4
13	Шинэ суурьшлын бүсэд мод үржүүлгийн талбай	Даяар трейд ХХК	127.7	122.4	5.3
14	Шинэ суурьшлын бүсийг эрчим хүчинд холбох /аймгийн ОНХС/	"Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК	300.0	276.0	24.0
Дүн			34,728.2	21,360.7	13,567.9

Эх сурвалж: Төрийн сангийн хуулга, санхүүжилтийн гүйцэтгэлүүд

Шинэ суурьшлын бүсийг эрчим хүчинд холбох ажлын санхүүжилтээс 24.0 сая төгрөгийг "Баянхонгор Эрчим хүч" ЦТХХК-д олгоогүй бөгөөд тус санхүүжилтийн авлагыг "Баянхонгор Эрчим хүч" ЦТХХК 2019 оны санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн, харин аймгийн ОНХС-ийн санхүүгийн тайланд өглөгөөр бүртгээгүй байгаа тул ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын санхүүжилтийн үлдэгдэл 24.0 сая төгрөгийг барагдуулахыг аймгийн Засаг даргад зөвлөв.

2.4. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

2.4.1.Захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллага үе шатны хяналтыг төсөл, арга хэмжээ тус бүр дээр харилцан адилгүй хэрэгжүүлж байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих зохиогчийн хяналтыг гүйцэтгэлийн явцад болон эцэст хянаж дүгнэлт гаргаж байгаа бол захиалагчийн хяналтыг барилга, инженерийн шугам сүлжээний хувьд аймгийн ГХБХБГ, замын хувьд тусгай зөвшөөрөл бүхий компаниар гүйцэтгүүлж байна.

Захиалагчийн хяналтыг зарим төсөл, арга хэмжээнд хангалтгүй хэрэгжүүлснээр дараах үр дагавар гарч байна.

- Сургуулийн барилга, 640 суудалтай сургуулийн барилгын зураг төсөвт тусгагдсан 86.5 сая төгрөгийн нэр бүхий 8 ажлыг одоо хүртэл хийгээгүй.
- 10 км авто замын ажлын зохиогчийн хяналтын дүгнэснээр замын өргөн болон буталсан чулууны марк болон чанарт хяналт хийж шинжилгээнд оруулалгүй ажлыг эхлүүлэн гүйцэтгүүлсэн.
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2018.10.18-ны 228 дугаар тушаалаар атлагдсан авто, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам, түүний хавсралт баримт бичиг хөтлөөгүй байгаа нь авто замд хийгдсэн далд ажлуудыг шалгах боломжгүй нөхцөл үүссэн

Шинэ суурьшлын бүсийн цахилгаан, цэвэр усан хангамжийн болон холбооны ажлуудыг зөвхөн материалын тендер зарлаж орон нутгийн болон төрийн өмчид компаниудаар гүйцэтгүүлж, өөрсдөөр нь хяналтыг хэрэгжүүлж байгаа нь хяналт бодитой чанартай хийх боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

Энэ талаар ГХБХБГ-ын хяналт хийх эрх бүхий мэргэжилтнээс тодруулахад "Инженерийн шугам сүлжээний ажлыг материалаар зарласан ба тусгайлсан ажлын зураггүй, төсвийг хэсэгчилсэн байдлаар салгасан ажилд хяналт хийх боломжгүй байдаг" гэсэн тайлбар өгөв.

Дээрх байдлаас үзэхэд захиалагчийн хяналтыг оновчтой, иж бүрэн цаг хугацаанд нь хийгээгүйгээс ажил зогсох хэмжээнд хүртэл сөрөг үр дагавар гарч байна.

Иймд захиалагчийн хяналтыг цаг тухай бүр нь холбогдох дүрэм журмын дагуу тавьж төсөл, арга хэмжээг чанартай гүйцэтгүүлэхэд анхаарч ажиллах албан даалгавар гаргаж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Ойн зурвасын усалгааны систем, хамгаалалтын хашааны материалыг "Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ хүлээн авч, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс шинэ суурьшлын бүсийн 3000 метрийн урттай 100 метрийн өргөнтэй талбайг хашаа хийж гүйцэтгэсэн байна. 2022 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс 09 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл усалгааны систем хийж гүйцэтгэсэн, БОАЖГ-ын мэргэжилтэн, байгаль хамгаалагч нар хяналт хийж ажилласан байна.

2.4.2. Шинэ суурьшлын бүсийн хөрөнгө оруулалтад тусгайлан хөндлөнгийн болон дотоод хяналт хийгдээгүй байна.

2.5. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

2.5.1 Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.

Шилэн дансны нэгдсэн цахим сайтад аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны тайлан, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулсан байна.

Хүснэгт 7. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Тайлангийн төрөл	2019	2020	2021	2022
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	2019.12.18	2020.01.03	2021.01.08	2022.01.03
Худалдан авах ажиллагааны тайлан	2020.01.03	2021.01.04	2022.01.06	2023.01.04

Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн цахим хуудас

Аудитын илрүүлэлт

- Харин Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019-2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнээс “Шинэ суурьшлын бүсийг эрчим хүчинд холбох”, “Баянхонгор аймгийн цөлжилт, газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах” ажлаас бусдыг байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байна.

Иймд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг бүрэн байршуулан зөрчлийг арилгах албан шаардлагыг Баянхонгор аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2.5.2 Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинэ суурьшлын бүсэд хийсэн бүтээн байгуулалтын ажлуудыг иргэд олон нийтэд нээлттэй мэдээлж ажилласан байна.

Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, хандиваар 2019-2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээнүүдийг аймгийн ИТХ болон ЗДТГ-ын албан ёсны цахим хуудаст мэдээлсэн байдлыг шалгахад Bayankhongor.gov.mn цахим хуудаст 21 удаагийн мэдээлэл, мөн Нээлттэй засаг-Нэг Баянхонгор цахим хуудас, Монголын үндэсний олон нийтийн телевиз, ETV HD телевизүүдэд шинэ суурьшлын бүсэд байгуулсан бүтээн байгуулалтын талаар нэвтрүүлэг контентыг түгээж, zindaa.mn, montsame.mn зэрэг цахим мэдээллийн хэрэгслээр олон нийтэд ил тод нээлттэй мэдээлж ажилласан байна.

Харин аймгийн ИТХ-ын албан ёсны цахим хуудас болох Bayankhongor.khural.mn цахим хуудаст Баянхонгор сумын шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай тогтоолыг байршуулж олон нийтэд түгээсэн байгаа нь Хот байгуулалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1⁷ дэх заалттай нийцэж байна.

⁷ Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, хотын захирагчийн ажлын алба нь энэ хуулийн хүрээнд гаргасан аливаа шийдвэрийн талаар тухай бүр олон нийтэд мэдээлнэ.

БҮЛЭГ 3. ШИНЭ СУУРЬШЛЫН БҮСИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ НЬ ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД БОДИТОЙ ХУВЬ НЭМЭР ОРУУЛСАН БАЙНА.

3.1. Шинэ суурьшлын бүсэд хийсэн хөрөнгө оруулалтын үр дүнд инженерийн шугам сүлжээ бий болж, нийгмийн зарим үйлчилгээг иргэдэд хүргэж эхэлсэн байна.

3.1.1. Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгаагүй байна.

Шинэ суурьшлын бүсэд баригдсан 14 ортой эрүүл мэндийн төвийн барилгыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 48 дугаар тогтоолоор Нэгдсэн эмнэлэгт эзэмшигч тогтоож, аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 13/04 дүгээр тогтоолоор Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолборт балансаас баланст шилжүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 13/11 дүгээр тогтоолоор шинэ суурьшлын бүсийн цэвэрлэх байгууламжийг 735.0 сая, “Цэвэр хот” төслийн хүрээнд нийлүүлсэн цэвэр усан хангамжийн материал хэрэгслийн 989.0 сая төгрөгийн хөрөнгийг “Чандмань- Баянхонгор” ХК-д эзэмшүүлэхээр, мөн ногоон байгууламжийг холбогдох байгууллагуудын хөрөнгөд бүртгэх шийдвэрлэсний дагуу хөрөнгөд бүртгэсэн байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим ажлууд ТӨБЗГ, аймгийн ИТХ-ын шийдвэр гараагүйгээс хөрөнгөд бүртгээгүй зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт

- Шинэ суурьшлын бүсэд баригдаж 2021 оны 11 дүгээр сард улсын комисс хүлээн авсан 5,166.1 сая төгрөгийн 640 хүүхдийн сургууль ашиглалтад орсон боловч бүртгэлд тусгаагүй;
- Шинэ суурьшлын бүсийн 10/0.4кВ-ын ЦДАШ-ийн ажилд 150.0 сая, 35 кВ-ийн ЦДАШ, дэд станцын ажилд 167.9 сая төгрөгийг зарцуулсан байхад эдгээр ажлыг хөрөнгөд орлогод авах арга хэмжээг авч ажиллаагүйгээс гэрээ байгуулсан 300.0 сая төгрөгийн хөрөнгийг одоог хүртэл нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Дээрх зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 6.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалтуудтай нийцэхгүй тул 5,466.1 сая төгрөгийн хөрөнгийг орлогод авах албан шаардлагыг аймгийн ОНӨГ-т хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт

- Мөн шинэ суурьшлын бүсийн гадна холбооны ажлын хөлсний дутуу авлага 70.8 сая төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй, материалын 450.2 сая төгрөгийг байгууллагын санхүүгийн бүртгэлд тусгаагүйгээр зарцуулалт хийсэн байна.
- Шинэ суурьшлын бүсийн гадна цэвэр, бохир усны материалыг нийлүүлэгч “Базардарь” ХХК-ийн нийлүүлсэн 995.0 сая төгрөгийн бараа материалыг “Чандмань-Баянхонгор” ХК нь санхүүгийн тайланд тусгалгүйгээр зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтуудыг зөрчсөн нь хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг алдагдуулах, дутагдуулах үр дагаврыг үүсгэж байгаа тул зөрчлийг арилгах албан шаардлагыг “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК болон “Чандмань-Баянхонгор” ХК-уудад хүргүүлэв.

“Баянхонгор эрчим хүч” ЦТХХК-аас шинэ суурьшлын бүсийн гадна цахилгаан хангамжийн барилга угсралтын тооцоогоор цалин хөлсөнд 80.1 сая, түлш шатахуунд 30.9 сая, нийт 111.0 сая төгрөг зарцуулахаар гаргасан бөгөөд Баянхонгор аймгийн

Засаг дарга “Баянхонгор эрчим хүч” ЦТХХК-тай 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр “Баянхонгор аймгийн Шинэ суурьшлын бүсийн цахилгаан угсралтын ажлын захиалагч гүйцэтгэгчийн гэрээ” байгуулж, ажлыг 111.0 сая төгрөгөөр гүйцэтгэж, санхүүжилтийг бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхээр болжээ.

“Баянхонгор эрчим хүч” ЦТХХК-ийн дансанд 2021.12.30-ны өдөр 29.7 сая, 2023.05.17-ны өдөр 20.0 сая, нийт 49.7 сая төгрөг “Хонгор тогтвортой хөгжил” НҮТББ-аас шилжиж ирсэн ба “Баянхонгор эрчим хүч” ЦТХХК-аас тус орлогын зарцуулалтыг гаргуулан авахад автокраны түрээсийн зардлын 2021 оны 12.0 сая, 2022 оны 8.0 сая төгрөгийг 2023.06.17-ны өдөр төлсөн, шатахууны зардалд 4.5 сая төгрөгийг зарцуулсан ба албан хаагчдын цалин хөлсийг олгоогүй, нягтлан бодох бүртгэлд авлага, өглөгөөр тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4¹ дэх , 14 дүгээр зүйлийн 14.4.4², 20 дугаар зүйлийн 20.2.5³ дахь заалтуудыг зөрчсөн тул бүртгэлд тусгах албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт

Баянхонгор эрчим хүч” ЦТХХК шинэ суурьшлын бүсэд 2022 онд 0.4кВ-ын 3.2 км агаарын шугам, 10 кВ-ын 1.2 км агаарын шугам барьж, 2 ширхэг КТП дэд станц угсарч ашиглалтад оруулсан, 2023 онд нийт 0.4кВ-ын 3.2 км агаарын шугам угсарч, 10 кВ-ын 0.2 метр шугам 10/0.4 кВ-ын КТП дэд станц 1 ширхгийг угсарсан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж, дуусан, ашиглаж байгаа эдгээр хөрөнгүүдийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байгаа тул асуудлыг холбогдох газруудад тавьж шийдвэрлэх нь зүйтэй байна.

“Баянхонгор эрчим хүч” ЦТХХК улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон шинэ суурьшлын бүсийн цахилгааны эх үүсвэрийн 1,195.0 сая төгрөгийг материалыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, материалыг зарцуулах тухай бүрд анхан шатны баримтыг бүрдүүлэн зарцуулан, 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар 888.1 сая төгрөгийн 63 нэр төрлийн материалын үлдэгдэлтэй байна. Энэ нь бараа материал алдагдах, дутагдах, солих эрсдэлтэй байгаа тул нягтлан бодох бүртгэлд тусгах албан шаардлагыг “Баянхонгор эрчим хүч” ЦТХХК-д хүргүүлэв.

3.1.2. Шинэ суурьшлын бүсэд 14 ортой эмнэлгийн зориулалтаар баригдсан барилгыг зориулалтын дагуу ашиглаагүй сургуулийн дотуур байрны зориулалтаар ашиглаж байна.

Шинэ суурьшлын бүсийн 640 хүүхдийн сургууль, 90 хүүхдийн цэцэрлэгийн цогцолбор нь 2021-2022 оны хичээлийн жилд ашиглалтад орсон, 102 багш, ажилтантай, сургууль 481 сурагчтай, цэцэрлэг нийт 326 хүүхэдтэй бөгөөд шинэ суурьшлын бүсэд цэцэрлэгийн 4 бүлэг үйл ажиллагаа явуулж байгаа ба 146 хүүхэд хамрагдаж байна.

Хүүхдийн тоглоомын иж бүрдэл, чийрэгжүүлэлтийн тоноглол, мод, бут суулгах, сүүдрэвч, гурван дамжлагат угаалтуур, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ариун цэврийн өрөөний тоноглол, хөл бөмбөгийн талбайн хиймэл зүлэг, резинэн будаг хийгдээгүйгээс бүрэн ашиглаж чадахгүй байгаа тул албан шаардлага өгсөн.

Мөн Шинэ суурьшлын бүсэд 14 ортой эмнэлгийн зориулалтаар баригдсан барилгыг зориулалтын дагуу ашиглаагүй сургуулийн дотуур байрны зориулалтаар ашиглаж 103 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулж байгаа тул эмнэлгийг зориулалтаар ашиглаж, сургуулийн дотуур байрны асуудлыг шийдвэрлэхийг аймгийн Засаг даргад зөвлөв.

Гэвч аймгийн Нэгдсэн эмнэлгээс 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 544 дугаар албан бичгээр аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т гүйцэтгэлээр санхүүжиж байгаатай

холбогдуулан үйл ажиллагаа явуулах боломжгүй байгаа тул яаралтай шийдвэрлэж өгөхийг хүссэн албан бичгийг аймгийн ИТХ-ын даргад хүсэлтийг тавьсан байна.

Үүний дагуу 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн аймгийн ИТХ-ын хуралдааны 13/04 дүгээр тогтоолоор үндсэн хөрөнгийг Баянхонгор сумын Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолборт эзэмшүүлсэн байна.

“Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК нь шинэ суурьшлын бүсэд 380 Вт хэрэглээтэй хэрэглэгч, аж ахуйн нэгж байгууллага 8, 220 Вт хэрэглээтэй ахуйн хэрэглэгч 418 нийт 426 иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан цахилгаан эрчим хүчээр хангаж байна.

Шинэ суурьшлын бүс нь цэвэр болон бохир усны нэгдсэн системд холбогдсоноор сургууль, цэцэрлэгийн цогцолбор, дотуур байр, 2 орон сууц, айл өрхүүдийн хэрэгцээг хангаж байна.

3.2. Шинэ суурьшлын бүсэд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгө, дэд бүтэц, бүтээн байгуулалт нь орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр үзүүлж байна.

3.2.1. Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон бүтээн байгуулалт орон нутгийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэсэн байна.

Шинэ суурьшлын бүс байгуулснаар орон нутгийн эрчимтэй хөгжлийг хангах, хөгжлийн түвшнийг жигдрүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх, хүн амын амьжиргааг сайруулах, иргэнд газар өмчлүүлэх боломж нөхцөлийг нэмэгдүүлэхэд оршино.

Баянхонгор сумын хүн амын тоо жилээс жилд нэмэгдэж, иргэнд өмчлүүлэх газрын нөөц багассан тул 2019 онд шинэ суурьшлын бүсэд иргэдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар олгохоор 2000 гаруй өргөдөл хүлээн авч, баг тус бүрээс 50, нийт 500 иргэнд сугалаагаар газар олгосноос 456 иргэнтэй “Шинэ суурьшлын бүсэд газар эзэмших, хариуцлагын гэрээ”-г 2019 онд нэг жилийн хугацаатай байгуулж, 2020-2023 онд 324 иргэнтэй газар өмчлөх хариуцлагын гэрээ байгуулсан байна.

Шинэ суурьшлын бүсэд 325 иргэнд газар олгох шийдвэр гарснаас 218 иргэн сугалаагаар авсан бол 107 иргэн нь газар хүссэн өргөдөл өгч газрыг авсан ба эдгээрээс 123 иргэн өөрийн өмчилсөн газартаа буусан байна.

Баянхонгор сумын Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг 2023 оны 04 дүгээр сард иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгох газрын 1800 гаруй өргөдлийг хүлээн авч, 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд шинэ суурьшлын бүсэд 463 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар олгохоор төлөвлөсөн байна.

Баянхонгор сумын шинэ суурьшлын бүсийн талаар хэр мэдээлэлтэй вэ?



Шинэ суурьшлын бүс байгуулах нь аймаг орон нутгийн хувьд ач холбогдолтой гэж үзэж байна уу?



Аудитаар иргэд, олон нийтээс цахимаар авсан 800, санал асуулгын хуудсаар авсан 100, нийт 900 санал асуулгын дүнг нэгтгэхэд шинэ суурьшлын бүс байгуулахыг санал асуулгад оролцогчдын 58 хувь нь ач холбогдолтой гэж үнэлсэн байгаа ч шинэ суурьшлын бүсийн талаар мэдээллийг 62 хувь нь хангалтгүй, 18 хувь нь хангалттай сайн мэдээлэлтэй гэж хариулснаас үзэхэд шинэ суурьшлын бүсэд хийгдэж буй хөрөнгө оруулалт, арга хэмжээний талаар иргэдэд мэдээллийг сайн түгээх нь зүйтэй байна.

Санал асуулгын нэгтгэлээс харахад санал асуулгад оролцогчдын 36 хувь нь орон нутгийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх асуудал хангалтгүй, 19 хувь нь хангалттай сайн гэж хариулсан бол шинэ суурьшлын бүсэд хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлыг 26 хувь нь хангалттай сайн, 31 хувь нь хангалтгүй гэж үнэлэн, 41 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон бүтээн байгуулалт орон нутгийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж чадаж байна уу?



Шинэ суурьшлын бүсэд хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлуудад хэр сэтгэл хангалуун байна вэ?



Дээрх гүйцэтгэл болон иргэдээс авсан санал асуулгаас үзэхэд Шинэ суурьшлын бүсэд 2018-2024 онд 3900 хүн ам суурьшуулах зорилтот түвшин хангагдахгүй байгаа тул иргэдэд мэдээллийг ил тод нээлттэй хүргэж, газар авахаар өргөдөл ирүүлсэн хүн амыг суурьшуулах ажлыг эрчимжүүлж, зорилтот түвшинг хангах зөвлөмжийг Баянхонгор сумын Засаг даргад хүргүүлэв.

3.2.2. Шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын ажлууд бүрэн хийснээр иргэдийн амьдрах орчин нөхцөлд таатай нөхцөл бүрдсэн байна.


Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ээс 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр ирүүлсэн 3/1221 дүгээр албан бичигт шинэ суурьшлын бүс бий болсноор орон нутагт гарсан нөлөөг дараах байдлаар тодорхойлжээ.

Хүснэгт №8. Шинэ суурьшлын бүсийн эерэг ба сөрөг үр дүн

Эерэг үр дүн	Сөрөг үр дүн
Засгийн газрын бодлого чиглэлийг орон нутагт хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэн, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг эрчимжүүлж, эдийн засгийн чөлөөт бүс, дагуу хот, шинэ суурьшлын бүсийг байгуулах чиглэлийн дагуу орон нутагт хийгдэж байгаа томоохон төсөл хөтөлбөр юм.	Шинэ суурьшлын бүсийн эдийн засгийн тооцоо, зураг төсөв, хүн амын эрүүл аюулгүй байдлыг хангасан орчны бүсийн судалгаа хангалтгүй.
Агаарын бохирдлыг бууруулах хүн амын төвлөрлийг багасгах зорилгоор суурьшуулах бүс болгож, одоогоор дэд бүтцийн ажлын 70 орчим хувийг буюу 4.2 км цэвэр ус, бохир усны эко систем, цахилгаан, дулаан, холбооны хэсэгчилсэн систем хийгдсэн.	Шинэ суурьшлын бүсэд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх томоохон үйлдвэрлэл байгуулж байгаа хэдий ч хүний нөөц хангалтгүй (нарийн мэргэжлийн инженерүүд)
Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 640 хүүхдийн суудалтай сургууль, цэцэрлэгийн барилга, өрхийн эмнэлэг баригдаж, орчин сайжирсан.	
“Ингэн-Эрдээ” ОНӨААТҮГ, мах ногооны зоорь, өвлийн хүлэмж зэрэг хөнгөн үйлдвэрийн парк бий болсноор ажлын байр нэмэгдэнэ.	
Шинээр шилжин суурьших иргэдэд газар олголтын боломж нэмэгдсэн.	

Аудитын явцад шинэ суурьшлын бүсэд амьдарч байгаа 56 иргэнээс санал асуулга авахад шинэ суурьшлын бүсийн агаарын бохирдлыг 38 иргэн бага, 10 иргэн дунд, 7 иргэн маш их гэж хариулжээ. “Шинэ суурьшлын бүсэд таны амьдрах тухтай орчин нөхцөлийг бүрдүүлж чадсан уу?” гэсэн асуултад 20 иргэн хангалттай сайн, 29 иргэн хангалтгүй, 5 иргэн мэдэхгүй гэж хариулж, 2 иргэн хариулаагүй байна.


■ А. Тийм ■ Б. Үгүй ■ В. Хариулаагүй



Шинэ суурьшлын бүсээс эмнэлгийн тусламж үйлчилгээ авахад хүндрэл үүсдэг үү? гэсэн асуултад 57 хувь нь тийм гэж хариулан, санал асуулгад оролцогчдын 96.4 хувь нь шинэ суурьшлын бүсэд эмнэлгийн үйл ажиллагаа явуулах шаардлагатай гэж үзжээ.

Шинэ суурьшлын бүсэд амьдарч байгаа иргэдийн 33 нь шинэ суурьшлын бүсэд баригдсан сургууль, цэцэрлэгт хүүхэд нь хамрагдсан гэсэн бол 22 нь хамрагдаагүй гэж хариулсан бөгөөд сурч боловсрох орчныг 41 иргэн нь таатай, сэтгэл хангалуун байдаг гэж, 11 иргэн нь дунд зэрэг, 2 иргэн нь хангалтгүй гэж үнэлжээ.

Шинэ суурьшлын бүс нь аймгаас 10 гаруй км-т байрладаг, санал асуулгаар авсан “нийтийн тээврийн асуудал ямар байдлаар шийдэгдсэн бэ?” гэсэн асуултад нийт оролцогчийн 64.2 хувь буюу 32 иргэн байхгүй, 14.3 хувь буюу 8 иргэн нь шугамын автобусаар, 14.3 хувь буюу 8 иргэн нь таксигаар явдаг гэж хариулснаас харсан байна.



Танд шинэ суурьшлын

бүстэй холбоотой ямар нэгэн санал байна уу? гэсэн асуултад санал асуулгад оролцсон 56 иргэний ихэнх нь замыг яаралтай засварлах, хүүхдийн тоглоомын талбайтай болох, хогийг маш удаан ачдаг тул хог ихтэй, нийтийн тээвэртэй болох саналыг өгсөн байна.

Аудитаар иргэд, олон нийтээс цахимаар ашиглан авсан 800, санал асуулгын хуудсаар авсан 100, нийт 900 санал асуулгаар Шинэ суурьшлын бүстэй холбоотой дараах саналуудыг ирүүлсэн байна. Үүнд:

- Дэд бүтцийг яаралтай шийдвэрлэх
- Замыг хурдан дуусгах
- Сугалаагаар олгосон газрын асуудлыг шалгаж шийдвэрлэх, сугалаагаар газар олгох нэрийдлээр дээр нь хашаа барьж бизнес хийж шахаж байгаа асуудлыг шалгаж иргэдэд газрыг олгуулах
- Анхнаас газрыг буруу сонгосон яаралтай үерийн далан барих
- Хүүхдийн тоглоомын талбай барих
- Гэр хороолол нь цэвэр бохирын шугам яаралтай татах хэрэгтэй. Өвөл бас л бөөн утаа болно.
- Эмнэлэг, эмийн сантай болох
- Шугамын тээвэр явуулах
- Оршин сууж байгаа айл өрхүүдийн хог хаягдлыг цаг тухайд нь ачдаг байх

Санал асуулгад оролцсон иргэдээс ирүүлж байгаа санал, шинэ суурьшилд үүсэж байгаа нөхцөл байдлыг харгалзан бүтээн байгуулалтын ажлуудыг нэн даруй дуусгах, үерийн даланг яаралтай шийдвэрлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Иргэдээс ирүүлсэн санал асуулгад шинэ суурьшлын бүсийн газар олголт хангалтгүй, хашааны чанар байдал муу, эко 00 асуудлыг бүрэн хийхгүй байгаа, хашааг нэгдсэн журмаар хийх нь буруу зэрэг саналууд ирсэн ба Баянхонгор сумын Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/201 дүгээр захирамжаар “Шинэ суурьшлын бүсэд аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн гэрээгээр хийж гүйцэтгэсэн евро хашаа, эко 00 барьсан ажилд хяналт шалгалт хийж, нэг бүрчлэн тоолох, тооцоог тулгах, чанарыг хянаж, үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах” ажлын хэсгийг сумын Засаг даргын орлогчоор ахлуулж, 9 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна.

Хяналт шалгалтын ажлыг чанартай, шуурхай гүйцэтгэж, иргэд, олон нийтэд шалгалтын үр дүнг нээлттэй мэдээлэх, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

Шинэ суурьшлын бүсэд бетон хавтан үйлдвэрлэх, эко 00-ын кольцо үйлдвэрлэх ажлууд хийгдэж байгаа тул иргэдийн амгалан тайван амьдрах нөхцөлийг хангах үүднээс жижиг дунд үйлдвэрлэл эрхэлж байгаа асуудлыг холбогдох албан тушаалтнууд анхаарах нь зүйтэй байна.

3.2.3 Шинэ суурьшлын бүсэд бий болсон бүтээн байгуулалтын ажлуудын үр дүнд орон нутгийн орлого нэмэгдэх, ажлын байр бий болох боломж бүрдэхээр байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд дараах үр дүн гарахаар байна. Үүнд:

- Ингэний сүүний үйлдвэрийн төслийн танилцуулгаар 270 байнгын, 210 түр ажлын байр бий болж, ингэний хатаасан сүү, ингэний шингэн хоормог, ингэний шар тос үйлдвэрлэж, өдөрт 363 кг хатаасан сүү боловсруулахаар төлөвлөж, анхны хөрөнгө оруулалтын 23.7 тэрбум төгрөгийг 10 жилд нөхөхөөр тооцон, ашгийг дараах байдлаар тооцсон байна.

Хүснэгт №9 . Ингэний сүүний үйлдвэрийн ашгийн тооцоолол

Үзүүлэлт	Дүн (тэрбум төг)
Нийт орлого	26.5
Нийт зардал	16.2
Ашиг	10.3

Эх сурвалж: Ингэний сүүний үйлдвэрийн төслийн танилцуулга

Хийсэн тооцооллоор хоногт 4 тонн ингэний шингэн сүүг 363 кг хатаасан сүү болгож байгаагаас үзэхэд 9.1 хувь нь бүтээгдэхүүн болж байгаа учир нэгж бүтээгдэхүүнд ногдох өртөг өндөр байна. Үйлдвэрлэсэн 1 кг хуурай сүүг БНХАУ-ын зах зээлд 783.0 мянган төгрөгөөр борлуулахаар тооцсон байна. Энэ нь үйлдвэрлэлийн хүчин чадлаар борлуулалтын үр ашгийг тооцсон байгаа нь зорилтот түвшинд борлуулах эсэх нь эрсдэлтэй байгаа тул эдийн засгийн тооцоо, нарийвчилсан судалгааг нотолгоонд тулгуурлан үндэслэлтэй хийхийг аймгийн Засаг даргад зөвлөв.

- Баянхонгор аймагт 2 өвлийн хүлэмжийн 0.1 га талбайгаас жилд 5.6 тонн ургац авч байгаа, шинэ суурьшлын бүсэд байгуулсан 2 өвлийн хүлэмжийг ажиллуулснаар 0.45 га талбайгаас 10.1 тонн ургац авах урьдчилсан тооцооллыг хийснээс өөр ажлын байрны тоо, орлого, зардлын тооцоолол, дүн шинжилгээ хийгээгүй байна.
- Мах, ногооны 1000 тонны зоорийг хэрхэн ашиглах талаар мэдээлэл аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т байхгүй байна.
- Баянхонгор сумын Гэгээн сумади сургуульд нийт 58 ажлын байр бий болж, орон нутгийн орлогод цалин, хөлс түүнтэй адилтгах орлогын татварт нийт 137.9 орчим сая төгрөгийг жил бүр төвлөрүүлэхээр байна.

Шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг орон нутгийн эдийн засаг, нийгэм, орон нутагт төвлөрөх орлогын суурь, түүний үр ашгийг урьдчилан тооцохыг аймгийн Засаг даргад зөвлөв.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 13,325.9 сая төгрөгийн зөрчил илэрсэнд, 3.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 13,322.1 сая төгрөгийн 10 албан шаардлага өгч, хариуцлага тооцох 3 албан шаардлагуудыг холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлэн, 1,009.0 сая төгрөгийн зөрчилд 11 заалт бүхий зөвлөмж хүргүүлэв.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасны дагуу шинэ суурьшлын бүсийн төлөвлөлт нь өсөн нэмэгдэж байгаа хүн амын тодорхой хэсгийг хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэж төлөвлөсөн байна.
2. Шинэ суурьшлын бүсийг байгуулах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалтын ажлуудыг үе шаттай хийгдэж байгаа ч хөрөнгийн үр ашгийг хүртэхэд санхүүжилтийн эх үүсвэрийг иж бүрэн шийдвэрлээгүй, төр хувийн хэвшлийн түншлэл хангалтгүй байна.
3. Шинэ суурьшлын бүсэд үерийн далангийн хамгаалалтыг төлөвлөөгүй, цэвэрлэх байгууламжийг суурьшлын бүсэд байгуулсан нь иргэдийн амьдрах орчин, бий болсон хөрөнгө оруулалтад аюул үүсэх эрсдэлтэй байна.
4. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсвийг магадлалаар баталгаажуулаагүйгээс ерөнхий хэсэгчилсэн төлөвлөгөө алдагдах (цэвэрлэх байгууламжийн төхөөрөмжийг айл өрхөд олгох газарт байгуулсан), гэрээнд заасан ажил, арга хэмжээг өөрчлөх, төсөв нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавар үүсэж байна.
5. Шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалт хэрэгжилтийн шатанд байгаа бөгөөд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр ашиг, үр дүн, ашиглалтын байдлыг дүгнэх хугацаа болоогүй байна.
6. Бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэхдээ хэрэгжилтэд тавих хяналт сул, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаагүй, бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй байгаа нь төслийн зорилтот түвшин хангагдахгүй байх эрсдэл үүсэж байна.

---oOo---

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД ТОЛИЛУУЛАХ НЬ

1. Шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөөний 2018-2024 оны зорилтод түвшин нь хугацаандаа биелэхгүй байх эрсдэлтэй байгаа тул бүтээн байгуулалтын гүйцэтгэлийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.
2. Шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтад төлөвлөсний дагуу төр, хувийн хэвшлийн түншлэл хангалтгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг иргэд хүртэх боломжийг удаашруулж байна.

ХОЁР. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА:

1. Шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтад төлөвлөсний дагуу төр, хувийн хэвшлийн түншлэлийг нэмэгдүүлж хувийн хөрөнгө оруулалтыг татах замаар санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох.
2. Шинэ суурьшлын бүсийн цэвэрлэх байгууламжийг төлөвлөсөн суурьшлын бүсээс гаргаж, зөвшөөрөгдөх координатад байгуулж, хамгаалалтын зурвас, аюулгүй байдлыг хууль журамд заасны дагуу хангаж ажиллах
3. Аудитаар иргэд олон нийтээс авсан санал асуулгаар ирүүлж байгаа санал, шинэ суурьшилд үүсэж байгаа нөхцөл байдлыг харгалзан эхний ээлжид авто замыг хүлээн авч, бүтээн байгуулалтын ажлуудыг дуусгаж, үерийн даланг нэн даруй шийдвэрлэх
4. Төсөл, арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийг зөрчиж инженерийн шугам сүлжээний ажлыг материал нийлүүлэх тендер зарлан төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлж байгаа байдлыг зогсоож, холбогдох хуулийг баримталж ажиллах.
5. Тендерийн үр дүнд шалгарсан аж ахуйн нэгж байгууллагатай техникийн тодорхойлолтыг өөрчлөлт оруулан шийдвэр гаргаж байгаа зөрчлийг таслан зогсоож, ажил хүлээн авах комисс журмын дагуу хариуцлагатай ажиллаж, бүтээн байгуулалтын үр дүнг аймгийн ИТХ-д тухай бүр нь танилцуулж шийдвэр гаргуулан ажиллах
6. Төр хувийн хэвшлийн сонгон шалгаруулалтуудтай холбоотой мэдээлэл, үр дүнг аймгийн ИТХ-ын хуралдаанд танилцуулан, хэлэлцүүлэх
7. Шинэ суурьшлын бүсэд хийгдэж байгаа цахилгааны ажлыг зураг, төсөвгүй гүйцэтгэж байгаа нь хууль, тогтоомж зөрчиж байгаа тул зөрчлийг арилгах
8. Бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэхдээ хэрэгжилтэд тавих хяналт сул, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах

ГУРАВ. БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГА Г.ЭНХБАЯР ТАНАА:

1. Шинэ суурьшлын бүсэд 2018-2024 онд 3900 хүн ам суурьшуулах зорилтот түвшин хангагдахгүй байгаа тул иргэдэд мэдээллийг ил тод нээлттэй хүргэж, газар авахаар өргөдөл ирүүлсэн хүн амыг суурьшуулах ажлыг эрчимжүүлж, зорилтот түвшинг хангах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

---оОо---

ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Бодлогын баримт бичгийн үялдаа холбоо

№	Бодлогын баримт бичгийн нэр	Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ	Баянхонгор аймгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилт
1	Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 оны хөтөлбөр	Сургуулийн барилга /640 суудал/	13. Аймгийн төвийн 5 дугаар сургуулийг ашиглалтад оруулж, 6 дугаар сургуулийг барьж, бусад шаардлагатай сургуулиудын хичээлийн байруудыг өргөтгөх, шинээр барих замаар сургуулиудын ээлжийн коэффициентийг бууруулж, 1 ангид суралцах хүүхдийн тоог 30-аас ихгүй болгоно
2		Эрүүл мэндийн төвийн барилга /14 ортой/	34. Шаардлагатай сумдад өрхийн эрүүл мэндийн төвийн барилгыг шинээр барих, өргөтгөх ажлыг зохион байгуулж, уламжлалт эмчилгээний болон эмчилгээний дараах сэргээн засах тасгуудыг бий болгоно
3	Баянхонгор аймгийн Засаг даргын 2021-2024 оны хөтөлбөр	Ингэний сүүний үйлдвэрийн барилгын ажил	3.2-т "Аймгийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, тамир тэнхээг сайжруулна", 3.2.1-т "Эдийн засгийн зөвлөгөөн зохион байгуулж, зөвлөл байгуулж ажиллана"
4		Ногоон тэжээлийн үйлдвэр	
5		Мах, хүнсний ногооны 1000 тонны агуулахын барилга	3.9.3. Стандартын шаардлага хангасан 1000 тонны төмс, хүнсний ногоо, махны зоорьтой болно
6		Баянхонгор аймгийн цөлжилт, газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах	5.1.3. Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээнэ
7		"Цэвэр хот" төсөл хэрэгжүүлэх	3.13.6. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж ашиглалтын дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж ухаалаг автоматжуулалтын системийг нэмэгдүүлнэ, суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ 5.2.7. Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангана 5.2.11. Орон нутгийн иргэдэд түшиглэсэн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ төслийг хэрэгжүүлнэ
8	Баянхонгор аймгийн Засаг даргын 2021-2024 оны хөтөлбөр	Шинэ суурьшлын бүсийн гадна холбооны шугам материал нийлүүлэх	3.13.12. Аймгийн төвийн 2 дугаар хэлхээ, Залуус хороолол, Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ
9		Цэвэрлэх байгууламж	
10		Цахилгааны эх үүсвэрийн ажил гүйцэтгэх, материал нийлүүлэх	
11		Аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээ	3.12.4. Шинэ суурьшлын бүсийн 8.5 км хатуу хучилттай автозамын барилгын ажлын зураг төсвийг хийлгэх, ажлыг гүйцэтгэнэ
12		Аймгийн шинэ суурьшлын бүсийн хатуу хучилттай 10 км авто зам	

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Баянхонгор аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Хавсралт2. Богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан хөрөнгө оруулалтын төлөвлөлт

(сая.төг)

№	Төсөл, арга хэмжээ	Санхүүжилтийн эх үүсвэр	Богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан он	Мөнгөн дүн
1	Баянхонгор хотын Шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн төлөвлөгөө хийлгэх	ОНХС	2018	41.4
2	Шинэ суурьшлын бүсийн дэд бүтцийн байгууламжийн зураг төсвийг хийлгэх	ОНХС	2019	60
3	Шинэ суурьшлын бүс, Залуус хороололд инженерийн шугам сүлжээ хийж, төв магистрал шугамд холбосон иргэн аж ахуйн нэгжид эхний ээлжид газар олгох асуудлыг шийдвэрлэх	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар	2019-2020	0
4	Сургууль, цэцэрлэгийн барилгыг шинээр барих, өргөтгөх, их засвар хийж хүүхдийн аюулгүй орчинд сурах, хөгжих нөхцөлийг бүрдүүлэх	Улсын төсөв	2019, 2021	5,166.10
5	Хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх болон эмнэлгийн эмч, ажилтнуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах	Улсын төсөв	2019	1,013.30
6	Амины орон сууц хөтөлбөрийн хүрээнд Хаус хорооллыг шинээр байгуулж төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг эхлүүлэх	Орон нутгийн хөрөнгө оруулалтын сан	2019	300
7	Шинэ суурьшлын бүсийн дэд бүтцийн байгууламжийн зураг төсвийг хийлгэх	ОНХС	2020	60
8	Хүнс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолборын ажлыг эхлүүлнэ	Улсын төсөв	2021-2023	12,000.00
9	Агро парк байгуулах ажлыг эхлүүлж зураг төсөв хийлгэх	Бусад эх үүсвэр	2021	0
10	Шинэ суурьшлын бүсийн 8.5 км хатуу хучилттай автозамын барилгын ажлын зураг төсөв	Замын сан	2021	50
11	Цэвэр хот төсөл хэрэгжүүлэх	Улсын төсөв	2021	1,000.00
12	Шинэ суурьшлын бүсэд мод үржүүлгийн газар байгуулах	БХНСАХЗ	2022	130
13	Баянхонгор аймгийн цөлжилт, газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах	Улсын болон орон нутгийн төсөв	2021	171
14	Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажил	Бусад эх үүсвэр	2022	576
15	Ингэний сүүний үйлдвэрийг бүрэн ашиглалтад оруулах	Бусад эх үүсвэр	2023	18,935.00
16	Аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээг хийх	Улсын төсөв	2022	7,032.90
17	Аймгийн шинэ суурьшлын бүсийн 10 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг хэрэгжүүлэх	Улсын төсөв	2023	8,000.00
Нийт дүн				54,535.70

Эх сурвалж: Баянхонгор аймгийн 2018-2023 оны хөгжлийн төлөвлөгөө



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 211 - 110570241
БНА - 2023/33/ШТА - ГА

Номгон

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн шинэ суурьшлын бүсэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа арга хэмжээ, бүтээн байгуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Цэвэр хот төсөл хэрэгжүүлэх - Баянхонгор, Баянхонгор сум" төсөл, арга хэмжээг гүйцэтгэхээр шалгарсан "Базардарь" ХХК нь тендерийн баримт бичгийн ТШӨХ-ийн 18.2 -д заасан "2019, 2020 онуудын борлуулалтын орлогын нийлбэрийн дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 60 хувиас багагүй", ТШӨХ 18.2 "2019, 2020 онуудын аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 60 хувиас багагүй хэмжээний ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байвал зохино. Гэрээг хавсарган ирүүлнэ" гэсэн шалгууруудыг хангаагүй байхад үнэлгээний хорооны олонхын шийдвэрээр шалгаруулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангаж, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдүүдийн ерөнхий, санхүүгийн, техникийн чадавх болон туршлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан үзүүлэлтээр хянан үзэж магадлна", 15 дугаар зүйл "Санхүүгийн чадавхыг үнэлэх", 15.3.4. "Тендерт оролцогчийн сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төстэй бараа, ажил, үйлчилгээний жилийн борлуулалтын талаарх мэдээлэл" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар

• 005040546

шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ" гэснийг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Хууль, журмыг зөрчсөн шийдвэр гаргадаг байдлыг таслан зогсоож, хууль зөрчсөн саналыг дэмжсэн үнэлгээний хорооны гишүүдэд хууль, журамд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээ авах.

2. Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 01-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Засаг дарга Д.Мөнхсайханд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

АУДИТОР

Б.НАРАНГЭРЭЛ





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 214- А0570241

Номгон

БНА - 2023 /33/ ИТА - ГА.

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн шинэ суурьшлын бүсэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа арга хэмжээ, бүтээн байгуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Сургуулийн барилга, 640 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/" төсөл, арга хэмжээг гүйцэтгэхээр шалгарсан "Хөх бүрдний эх" ХХК нь 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Баянхонгор аймгийн ГХБХБГ-ын дарга болон "Хөх бүрдний эх" ХХК-ийн захирлын хооронд "Барилгын үлдэгдэл ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулсан бөгөөд уг гэрээнд зураг төсөвт тусгагдсан 86.5 сая төгрөгийн нэр бүхий 8 ажлыг 2022 оны 06 дугаар сарын 22-ны дотор хийж гүйцэтгүүлэхээр тусгасан ч одоогоор тус ажлууд хийгдээгүй, мөн барилгын гадна талын пасад хэсэгчлэн хуурч унасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх "Худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7 "Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Иргэний тухай хуулийн 343 дугаар зүйлийн 343.1 дэх "Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь захиалагчийн буюу өөрийн материалаар гэрээнд заасан ажил гүйцэтгэх, захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ", 350 дугаар зүйлийн 350.1.1 дэх "Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх", 351 дүгээр зүйлийн 351.1.2 дэх "Гүйцэтгэсэн ажлын үр дүнг хугацаанд нь хүлээн авах", Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2.1.4 дэх "Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн багцад

• 005040554

тухайн жилд батлагдсан төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллана”, 4.1.12. дэх “Төслийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дээрх хэрэгжээгүй 86,494,104 /наян зургаан сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга нэг зуун дөрвөн / төгрөгийн ажлыг захиалагчтай байгуулсан гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах, үүрэг гүйцэтгээгүй удааширснаас төрд учирсан хохирлыг гүйцэтгэгч нараас нэхэмжлэн хууль хяналтын байгууллагад шилжүүлэн зөрчлийг арилгах.

2. Албан шаардлагын биелэлтийг 2024 оны 08 дугаар сарын 01-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Засаг дарга Д.Мөнхсайханд даалгав¹.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

А.ЦЭЭНЯМ

Б.НАРАНГЭРЭЛ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 215/АД571121
БНА-2023/33-Ш ТА-ТА

Номгон

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн шинэ суурьшлын бүсэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа ажил, арга хэмжээ, бүтээн байгуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шинэ суурьшлын бүсэд ундны усны эх үүсвэрт усан сангийн хамгаалалтын хашаа, торон хашаа, харуулын байр, насос станцын барилгын ажил хийгдээгүй байгаа нь эрүүл ахуй, аюулгүй байдалд эрсдэл учирч болзошгүй нөхцөл байдал үүсэж байна.

Энэ нь Хот суурины усан хангамж, ариутгах татуургын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх “Улсын онц чухал объектод хамаарах ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтыг дотоодын цэрэг гүйцэтгэж, бусад ус хангамжийн эх үүсвэр нь энгийн харуул хамгаалалттай байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Усны эх үүсвэрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангаж Хот суурины усан хангамж, ариутгах татуургын тухай 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтыг хэрэгжүүлж зөрчлийг арилгах.

• 005040558

2. Албан шаардлагын биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 01-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгав¹.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН ²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ

АУДИТОР

Н.БАТЧИМЭГ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 216/А0571/21
БНА - 2023/33 - ШТА-ГА

Номгон

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн шинэ суурьшлын бүсэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа ажил, арга хэмжээ, бүтээн байгуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шинэ суурьшлын бүсийн гадна холбооны ажлын материал нийлүүлэх ажлын техникийн тодорхойлолтод тусгагдсанаар “Нью бест хаус” ХХК нь нэг барилга, 126 худаг, 30 нэр төрлийн бараа материал нийлүүлэхээс “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-д 20 нэр төрлийн бараа материалыг хүлээлгэн өгч нэг барилга, 126 худгийг хүлээлгэн өгөөгүй, 10 нэр төрлийн бараа материалыг нийлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх “Худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах, 46.4.6 дахь “Гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах”, Иргэний хуулийн 350 дугаар зүйлийн 350.1 дэх, “Ажил гүйцэтгэгч нь дараах үүрэг хүлээнэ”, 351 дүгээр зүйлийн 351.1 дэх “Захиалагч дараах үүрэг хүлээнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

• 005040560



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар

217/10560236

Номгон

БНА-2023/33-ЦТА-ГА

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Баянхонгор аймгийн Шинэ суурьшлын бүсэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа арга хэмжээ, бүтээн байгуулалт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн шинэ суурьшлын бүсийн хатуу хучилттай авто зам, 10 км авто замын гүйцэтгэгч “Түмдэлгэрэх” ХХК-ийн ажилд зохиогчийн хяналт хийж дараах 5 төрлийн зөрчил илэрч ажлыг зогсоосон байна. Үүнд:

- Авто замын барилгын ажилд зориулж хийсэн буюу дугуй цохигчийг газар дээр нь цутгаж байгалиар нь хатаасан байгаа нь бат бэхийн үзүүлэлтийг хангаж байгаа эсэх эргэлзээтэй тул итгэмжлэгдсэн лабораториор магадлуулах шаардлагатай.
- Буталсан чулуун суурийн материал нь техникийн шаардлагын бүлэг 900-ийн 902, 903 дугаар заалтад заасан материалын ангилал, материалын шаардлагыг хангахгүй байна.
- Авто замын зарим хэсэгт асфальтан хучилт хийгдсэн байгаа ба асфальт бетон хучилт хийхдээ битум цацлага хийгээгүй мөн авто замын зураг төслийн дагуу өнгө асфальт бетон хучилт 3см, суурь асфальтан хучилт 4 см байсныг нийлүүлэн нэг үе болгож авсан.
- Зохиогчийн зүгээс авто замын ажлын батлагдсан төсөвт өртөгт тааруулан өөрчлөлт оруулахдаа замын хийцэд болон өргөнд өөрчлөлт ороогүй. Зөвхөн дугуйн зам, явган замын хучилтыг хийхгүйгээр тусгасан байгаа. Одоо хийгдсэн байгаа далангийн өргөн зураг төсөлд заасан хэмжээнд хүрэхгүй байна. Өргөсөлтийг шаталсан хэлбэрээр хийж гүйцэтгэх шаардлагатай.
- Зам барилгын ажлын шатанд техник технологийн хяналтыг гүйцэтгэж байгаа байгууллагын төлөөллөөс зураг төсөл зохиогчтой хийсэн уулзалтад ирээгүй. Зам тээврийн хөгжлийн сайдын 2018.10.18-ны 228 дугаар тушаалаар баталсан авто, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам, түүний хавсралт баримт бичиг хөтлөөгүй байгаа нь авто замд хийгдсэн далд ажлуудыг шалгах боломжгүй нөхцөл үүссэн.

Дээрх зөрчил нь Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Барилга байгууламж дараах шаардлагыг хангасан байна”, 14.1.1.-т “Зураг төслийн дагуу баригдсан байх” гэснийг зөрчсөн байна.

• 005040564

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн "4.2.1.8 байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй, 4.2.1.11 дэх "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан, зогсоож, давтан гаргуулахгүй үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аймгийн шинэ суурьшлын бүсийн хатуу хучилттай авто зам, 10 км авто замын ажлын зохиогчийн хяналтаар илэрсэн зөрчилд захиалагчийн хяналтыг хийн зөрчлийг арилгуулж, ажлыг гэрээт хугацаанд чанартай гүйцэтгүүлэн хүлээн авах.

2. Албан шаардлагын биелэлтэд хяналт тавьж, биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан, аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн Т.Хишигбаатар нарт даалгав¹.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН ²:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

А.ЦЭЭНЯМ

Б.АЗБАЯР



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 219 - А0570241

Номгон

БНА - 2023/33/ШД - ГА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн шинэ суурьшлын бүсэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа арга хэмжээ, бүтээн байгуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019-2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан 12 гэрээг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан 12 гэрээг бүрэн байршуулан зөрчлийг арилгаж,

• 005040570

биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 01-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Засаг дарга Д.Мөнхсайханд даалгав².

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

АУДИТОР

Б.НАРАНГЭРЭЛ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар